




# СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.05.07 №18 (10695)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн хошууч Д.Оюунгэрэл

## САЙД Н.ЭНХБОЛД ШАВ ТАВИХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГААНД ОРОЛЦОО

ҮБХИС-ийн Ном, мэдээллийн төвийн шавийг тавьж барилгын ажлыг эхлүүлээ. Ёслолын ажиллагаанд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, сайдын зөвлөх Д.Бүрэнтогтох, ТЗУГ-ын дарга, хурандаа Ө.Эрдэнэ-Очир болон ҮБХИС-ийн захирал, хурандаа П.Жаргалан нарын албаны хүмүүс оролцсон юм.

Энэ үеэр Батлан хамгаалахын сайд Н.Энхболд "Монгол Улсын Засгийн газраас Батлан хамгаалах чадавх, Зэвсэгт хүчнээ хөгжүүлэх талаар онцгой анхаарч ажиллаж байгаагийн нэг илрэл болох энэхүү барилгын шавь тавих ёслолын ажиллагаанд оролцож байгаадаа баяртай байна. Даяаршлын, аж үйлдвэрийн мөн мэдээллийн эрин зуун ч гэж хэлэгддэг энэ цаг үед цөөн хүн амтай, хүч чадлаараа ядмагхан манай улсын хувьд юуны түрүүнд хүнийхээ хөгжилд анхааран, иргэддээ эрдэм боловсрол, хүмүүжил, ёс суртахуун олгосноороо өрсөлдөөнтэй ертөнцөд өөрсдийгөө авч явах, аюулгүй байдлаа хангах



боломжтой. Хүн нэг бүрийн хичээл зүтгэл, мэдлэг оюун нь улс эх орныг хөгжил өөд хөтөлнө. Энэ талаас нь харахад Монгол Улсын Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулдаг боловсон хүчнийг нь бэлддэг, хамгийн ууган боловсролын байгууллага маань шинэ эрдмийн өргөөтэй болох гэж байгаа нь сайн хэрэг юм. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх энэ салбарт онцгойлон анхаарч Батлан хамгаалахын удирдлагын академийн барилгын ажлыг

эхлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Барилгын ажил энэ ондоо дуусах байх. Харин одоо Ном, мэдээллийн төвтэй болохоор зорьж байна. Энэ нь зөвхөн цэргийнхнийгээ дэмжиж байгаа асуудал биш юм. Дэлхийд үнэлэгдэх, аль ч улс орны эрдэм, боловсролтой сэхээтнүүдээс дутахааргүй боловсон хүчинтэй болох шаардлага бий гэдгийг харгалзаж үзсэний нэг илрэл" гээд барилгын ажлыг гүйцэтгэх компанийн ажилтнуудад амжилт хүслээ.

## АУГАА ЭХ ОРНЫ ДАЙНЫ ЯЛАЛТЫН БАЯРЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм Монгол нөхөд өө!  
Энэ жил Аугаа Эх орны дайны ялалтын 75 жилийн ой тохиож байна. Ялалтын баяр бид бүхнийг нэгтгэдэг. Энэ өдөр бол манай дайчид, ар талд ажиллагсад болон Германы фашизм, түүнийг дагалдагсдыг ялсан ялалтыг авчирсан ачтан хэн бүхний гавьяаг мөнхөд дурсах өдөр юм.

Ялалтыг бид асар их үнээр авчирсан. Дайсан манай мянга мянган хотыг сүйтгэсэн, олон арван мянган тосгоныг шатаасан, сая сая хүн амь үрэгдсэн. Дайсны өөдөөс тэсвэр хатуужил, эр зориг, эв нэгдлийн ачаар бид эрх чөлөө, тусгаар тогтнолоо хамгаалан, Европын

орнуудыг чөлөөлж, дэлхий нийтийг мөхөл, боолчлолоос аварч чадсан.

Аугаа Эх орны дайн Зөвлөлт Холбоот Улсын ард түмэн болон Монголын ард түмний найрамдал, нөхөрлөл эвдэршгүй болохыг нотолсон. Оросын Холбооны Улс болон хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан улсууд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хамтын ялалтад оруулсан ихээхэн хувь нэмрийг хэзээ ч мартаггүй. Монголчууд 1939 онд Халхын голд Зөвлөлтийн дайчидтай хамт Японы милитаризмын халдлагыг зогсоосон, фашистын булаан эзлэгчдийн эсрэг тулалдсан Улаан армид үнэлж баршгүй тусламжийг үзүүлсэн. Мөн 1945 онд хамтдаа Квантуны армийг бут цохисноороо бахархах зүй ёсны эрхтэй. Монголд түүхийн сургамжийг мартаггүй, түүхийг гуйвуулж бичихийг эсэргүүцэж, бидний эцэг, өвгөдийн нийтлэг гавьяаг нэр төртэй хүндэтгэн дурсдаг талархаж байна.

Коронавирусийн цар тахлын улмаас Орос Улсад Ялалтын баярын ёслолын арга хэмжээнүүд хойшилсон, гэхдээ цуцлагдаагүй. Баярын арга хэмжээнүүд зайлшгүй болно. Яруу алдарт түүхээ цаашид хайрлан хамгаалцааг!

Аугаа Эх орны дайны ялалтын баярын мэнд хүргэе!

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД И.КАЗИЗОВ

## БИДНИЙ ХАМТЫН БАЯР

Аугаа Эх орны дайн бол дэлхийн түүхийг өөрчилсөн төдийгүй олон улс орны оршин тогтнох үйл явц, тэр дундаа Монгол Улсын тусгаар тогтнолд нөлөөлсөн өөрөө бидэнд хамгийн их хамааралтай түүхэн үйл явдал билээ. Аугаа гэх бүхий л тоо баримт энэ дайнд х а м а а р л т а й байдаг. Дайны эхэнд хоёр талаасаа 10 сая орчим цэрэг, 16 мянга орчим их буу, миномёт, 30 мянга орчим танк, нисэх онгоц оролцжээ. Зөвхөн 1941-1945 оны хооронд ЗХУ-ын хэмжээнд дайнд дайчлагдсан хүний тоо гэхэд 34 сая, Германы талаас 19 саяд хүрчээ. Дайны хохирол гэхэд ЗХУ-ын тал 26 сая хүнээ алдсан аймшигтай тоо баримт түүхийн гэрч болжээ.



Үргэлжлэл нь II нүүрт)

## ЗАХИРАГЧ НАРТАЙ ЦАХИМААР ХУРАЛДАВ

Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагч нартай цахим хурал хийлээ. Хурлын эхэнд хошууч генерал Д.Ганзориг Зэвсэгт

дадлага, уралдаан, тэмцээнүүд түр хугацаанд завсарласан тухай, Зэвсэгт хүчний эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй ажлуудын талаар товч танилцууллаа. Мөн нэгтгэл, ангиудад тулгамдаж буй

хангах, хүн нэг бүрийн цэргийн сургалт бэлтгэлийг дээшлүүлэх, цэргийн алба, сахилга батыг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг чанд сахин мөрдөхөд онцгой анхаарч ажиллахыг даалган коронавирусийн халдварын тархалт буурахад төлөвлөгөөт ажил, арга хэмжээгээр бүрэн хэрэгжүүлэхийн төлөө Зэвсэгт хүчний удирдлага, бие бүрэлдэхүүн өндөр ачаалалтай ажиллахыг анхааруулав. Түүнчлэн Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагч нарт бие бүрэлдэхүүн, тэдгээрийн ар гэрийнхнийг коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх хүрээнд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Монгол Улсын Эрүүл мэндийн яамнаас гаргасан заавар, зөвлөмжийг ягштал дагаж, Улсын онцгой комиссын шийдвэрүүдийг биелүүлж байх зэрэг олон асуудлаар үүрэг, чиглэл өглөө. Цахим хуралд ЗХЖШ-ын орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар тэргүүтэй даргын зөвлөлийн гишүүд бүрэлдэхүүнээрээ оролцсон юм.



хүчний 2020 оны үйл ажиллагаа нь төлөвлөгөө, хуваарийн дагуу явагдаж байгаа ч коронавирусийн халдварын нөхцөл байдлаас хамаараад олон улсын сургууль, хамтарсан сургалт

асуудлыг захирагч нараас нь сонсож, шийдвэрлэх хүрээнд зарим арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Хурлын төгсгөлд бие бүрэлдэхүүнийхээ бэлэн байдлыг

## АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ НАР ЧУУЛЛАА

АНУ-ын Агаарын цэргийн Энэтхэг-Номхон далайн командлагч, генерал Чарльз Брауны санаачилгаар бүс нутгийн орнуудын Агаарын цэргийн командлагч нарын цахим хурал зохион байгуулагдлаа. Хуралд нийт 21 орны Агаарын цэргийн командлагч нар оролцон, коронавирусийн цар тахлын аюулаас иргэдээ хамгаалах, тархалтыг бууруулах, зогсоох чиглэлээр тухайн улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн үр дүн, туршлага, сургамж болон энэхүү арга хэмжээнд Агаарын цэргийн гүйцэтгэж буй

үүрэг, оролцооны талаар мэдээлэл хийж, харилцан санал солилцов.

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, бригадын генерал О.Энхбаяр Монгол Улсын Засгийн газраас энэхүү аюулт өвчний халдвараас урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, туршлага, сургамж, цар тахлыг бууруулах, таслан зогсооход Зэвсэгт хүчин, Агаарын цэргийн оруулж буй хувь нэмэр багагүй байгааг цохон тэмдэглээд бүс нутгийн орнуудын Агаарын цэргийн 2020 оны хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн олон

арга хэмжээ цуцлагдаж, тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байгаа ч цаашид цар тахлыг хамтын хүчээр даван туулж, удахгүй нүүр нүүрээ харан баяртай уулзахын өрөөл дэвшүүлээ.

Мөн АНУ-ын Агаарын цэргийн командлагчаар дэвшин томилогдож байгаа Энэтхэг-Номхон далайн Агаарын цэргийн командлагч, генерал Чарльз Браунд баяр хүргэн, шинэ албанд нь амжилт хүсэж хоёр орны Агаарын цэргийн хамтын ажиллагаа цаашид улам өргөжин хөгжинэ гэдэгт итгэж байгаагаа илэрхийллээ.

## ТЭСРЭХ БӨМБӨГҮҮДИЙГ АЮУЛГҮЙ БОЛГОЛОО

Зэвсэгт хүчний алба хаагчид иргэдийн амь нас, аюулгүй байдалд ноцтой хохирол учруулж болох тэсэрч, дэлбэрэх галт хэрэгслүүдийг самнаж илрүүлэн, устгалд орууллаа.

Тодруулбал, Төв аймгийн аймгийн Баянжаргалан сумын Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, ахлах ахлагч Б.Соронзонбатын "Манай сумын нутагт тэсэрч, дэлбэрэх сум, галт хэрэгсэл байна" гэсэн дуудлагын дагуу ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон Тэсэрч, дэлбэрэх зүйлийн хайгуул устгалын бүлгийнхэн Баянжаргалан суманд ажиллалаа.

Томилгоот бүрэлдэхүүн сумын төвөөс хоёр галт хэрэгсэл, сумын төвөөс 23 километрийн зайд орших "Улаан-Ухаа" багийн нутаг дэвсгэрээс "ОФАБ-250", "ФАБ-250" загварын байлдааны нисэх онгоцны бөмбөг болон 30 миллиметрийн байлдааны сумыг олж илрүүлэн, устгаж аюулгүй болгосон байна.

Тус газарт хуучин ЗХУ-ын нисэхийн цэргийн анги байрлаж байсан бөгөөд хэрэв тэдгээр галт хэрэгслүүдийг яаралтай олж илрүүлээгүй бол ойролцоо оршин суудаг иргэдийн амь насанд ноцтой аюул учрах байв.

Нутгийн зон олны зүгээс учирч болох эрсдлээс амь нас, эд хөрөнгийг нь авран хамгаалсан Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд талархлаа илэрхийлсэн юм.

Энэ дашрамд, Баянжаргалан сумын Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, ахлах ахлагч Б.Соронзонбатын сонор сэрэмж эрсдэл үүсэхээс мөн адил урьдчилан сэргийлснийг дурдах нь зүйтэй.

Зэвсэгт хүчний томилгоот бүрэлдэхүүн тус сум, орон нутгийн эрсдэл бүхий газруудад дахин самналт хийхээр төлөвлөөд байна.



## ХУУЛЬ ТОГТООМЖИД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар Төрийн албаны /шинэчилсэн найруулга/ тухай хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам" болон 2019 оны 07 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-уудад Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжид нийцүүлэн зарим өөрчлөлтийг орууллаа. Тодруулбал, "Төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын

3.1 дэх хэсэгт "3.1.10. сонсогчийн цэргийн сургуульд суралцсан хугацаа", "3.1.11. хугацаат цэргийн алба хаасан хугацааг тус тус нэмж оруулсан бол "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын хоёр дахь хэсэгт сонсогчийн цэргийн сургуульд суралцсан хугацаа, хугацаат цэргийн алба хаасан хугацааг тус тус нэмж оруулсан байна. Ингэснээр төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагад ажилладаг төрийн албан хаагч өмнө нь төрийн цэргийн байгууллагад алба хаасан бол тухайн нэмэлтээр оруулсан хугацааг төрийн алба хаасан хугацаа болон тэднийг өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоход тооцох чухал ач холбогдолтой шийдвэр боллоо.

## ЦЭРГИЙН ЭРДЭМТДИЙН ЭЭЛЖИТ БҮТЭЭЛҮҮД УНШИГЧДЫН ГАРТ ОЧИЖ БАЙНА

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтдийн хамтран бүтээсэн "Цэргийн операцын урлаг" бүтээл уншигчдын гарт очлоо. Монгол цэргийн өв уламжлал, үндэсний цэргийн урлагийг онол, практикийн талуудаас нь шинжлэн судалсан энэхүү бүтээл нь Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний цэргийн боловсрол, сургалт бэлтгэлийн бодлого, хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулахуйц бүтээл юм. Номын ерөнхий редактор, зохиогчоор Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор, чөлөөнд байгаа хурандаа Ш.Паламдорж, редактороор Батлан хамгаалахын сайдын цэргийн зөвлөх, профессор, чөлөөнд байгаа дэслэгч генерал Ц.Дашзэвэг, зохиогчоор шинжлэх ухааны доктор, профессор, чөлөөнд байгаа хошууч генерал О.Уржин, доктор, профессор, хурандаа Ч.Баттулга нар ажиллажээ.

Хэвлэлтээс гараад удаагүй байгаа номын дээжээсээ Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрийн цэргийн командлалын удирдлагуудад өргөн барьсан бөгөөд энэхүү бүтээлийн агуулга нь армийн операц, тусгай болон дайны бус цэргийн операц (уламжлалт бус операц)-ын онол, арга зүй, гадаадын зарим улсын операц явуулах арми, цэргийн бүлэглэлийн туршлага, сургаж, өөрийн Зэвсэгт хүчний операц явуулах онол, арга зүйн үндэс, өнөөгийн практикийг шинжилсэн, хайгуулд хөтөлсөн хамтын нэг сэдэвт бүтээл юм. Шинж чанарын хувьд нэг сэдэвт, сургалт, судалгаа, шинжилгээний



хамтын бүтээл учраас үүнийг батлан хамгаалах болон цэргийн мэргэжилтэн, цэргийн мэргэшсэн судлаач, багш нар болон Аюулгүй байдал, Батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаанаар магистр, доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалахаар суралцагчид, орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгаа хариуцсан төрийн албан тушаалтнууд, цэргийн дээд боловсролтой бэлтгэл болон чөлөөнд байгаа генерал, офицерууд мөн сонирхогчид ашиглах боломжтой бүтээл аж.

Мөн энэ үеэр бас нэг бүтээл уншигчдын гарт очсон нь "Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний байгуулалт, удирдлагын шинэчлэл" хэмээх ном байлаа. Номын зохиогч Батлан хамгаалахын сайдын цэргийн зөвлөх, профессор, чөлөөнд байгаа дэслэгч генерал Ц.Дашзэвэг бөгөөд тэрээр номынхоо тухай "Батлан хамгаалах бодлого нь үндэсний аюулгүй байдлыг хангах гол асуудлын нэг ба түүнийг тодорхойлох, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь нэг удаагийн үйл хэрэг биш, он удаан жил дамжин байж хэрэгжиж, ашиг тусаа өгдөг онцлогтой. Энэ номд Зэвсэгт хүчний байгуулалт, удирдлагын

эдүгээгийн шинэчлэлийн гол зангилаа асуудлыг хэрэгжүүлэх арга замын тухай өгүүлнэ" хэмээгээд Зэвсэгт хүчний генерал, офицерууд эрхэлж буй албандаа хэрэглэж, цэргийн сургуулийн багш, судлаач, оюутан, сонсогчид эрдэм судлал, сургалтдаа ашиглана хэмээн найдаж байна" гэлээ.

ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг номын зохиогч нарт хандан "Эрхэм эрдэмтэн, докторууддаа баярлалаа. Зэвсэгт хүчний өөрчлөлт, шинэчлэлд та бүхний мэдлэг, боловсрол, туршлага, сургаж хамгаас чухал юм. Эрдэмтэн та бүхний хэлсэнчлэн орчин үеийн шинжлэх ухааны ололт, амжилт, цэргийн зэвсэглэл, техникт нэвтэрч буй өөрчлөлт болоод бэлэн байдлыг хангахтай уялдуулаад Зэвсэгт хүчний бүрэлдэхүүний сэтгэлгээний өөрчлөлтөд анхаарч байна. Онол, арга зүй, шинжилгээний энэхүү бүтээл орчин цагийн болон алсын хандлагаараа үнэ цэнтэй сайхан бүтээл болжээ. Манай бие бүрэлдэхүүний ширээний ном болно гэдэгт итгэлтэй байна" гээд бүтээл туурвигчдыг ЗХЖШ-ын "Жуух бичиг"-ээр шагнасан юм.

## БИДНИЙ ХАМТЫН БАЯР

(Түрүүч нь I нүүрт)

Цаг хугацааны түүхэнд аливаа ард түмнийг өөр өөрсдийн хувь тавилан нь хүлээж байдаг. Үүнийг аугаа түүх болгож чадсан улс орон тун цөөхөн. Үүний нэг нь Орос-Монголын ард түмэн билээ.

Монгол Улсын хөгжил дэвшил, тусгаар тогтнолыг 1921 оноос ЗХУ-тай шууд холбон авч үзэж байсны хувьд дайн эхэлсэн өдрөөс Германы эсрэг Зөвлөлтийн ард түмний хийж буй тэмцэлд бид нэгдэн орсон юм. Ийнхүү Монгол Улс Аугаа Эх орны дайны үед ЗХУ-ын талд баттай зогсож, фашизм, нацизм, милитаризмын эсрэг эвсэлд оролцож байр сууриа дэлхий дахинд эн тэргүүнд албан ёсоор тунхаглан зарласан анхны улсуудын нэг болжээ.

Монгол Улс, ЗХУ-тай 1936 онд байгуулсан харилцан тусалцах протоколын дагуу хүлээсэн үүргээ үнэнчээр биелүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлээд зогсохгүй сайн дураараа ЗХУ-д бүх бололцоогоороо туслахыг ард түмэндээ уриалсан билээ.

Бид "Бүхнийг фронтод", "Бүхнийг ялалтын төлөө" уриан дор Эх орны дайны жилүүдэд нийтдээ 80 гаруй сая төгрөгийн зургаан удаагийн бэлгийн цуваа, 53 танк, 12 нисэх онгоц, 300 килограмм алт, 100 мянган

ам.доллар, олон мянган тонн хоол хүнс, эд хэрэглэл, ноос, нэхий мөн дайны үеийн стратегийн хамгийн чухал түүхий эд болох гянт болдыг нийлүүлэгч цорын ганц орон нь байсан юм. Оросууд дээрх түүхий эдгүйгээр дайсны танкийн их бие, хамгаалалтыг нэвтлэх сум хийх боломжгүй байлаа. Мөн монгол хонины ноосоор хийсэн эсгий гутал, нэхий дээл нь фронтын дайчдад хамгийн үнэт бэлэг болж байжээ.

Эх орны дайн биднээс хамаагүй хол өрнөж байсан ч бид тэж бодолгүйгээр Монголын ард түмэн чин сэтгэлээсээ ялалтын төлөө зүтгэн Оросоос авч байсан хоол хүнс, тамхи, ахуйн хэрэглэл, лаа, шүдэнз гээд бүхий л зүйлсээ хэмнэн гамнаж ганц ч гэсэн дулаан нэхий дээлээ фронтын дайчин нөхдөдөө өгч байсан ийм түүхийг энэ дэлхийн ямар ч улс үндэстнээс олж харахгүй биз ээ. Монгол-Оросын ард түмний сэтгэл ийм л гайхамшигтай байж ялалтад хөтөлжээ.

Зөвхөн эд материалын тусламжаас илүү бид Оросын ард түмэнд сэтгэл санааны асар том дэмжлэг үзүүлсэн юм. Хайрт аав, ээж, ах, эгч, хань, үр хүүхдээ алдсан фронтын дайчдын сэтгэлийг Монголын ард түмний ариун нандин сэтгэлийн учигтай захидал дэвтээж тэдний ээж, аав, эхнэр, хүүхэд, гэр бүлийг

нь орлон, байлдах чадварыг нь өргөн бидний ард Монгол хэмээх нэгэн хүчирхэг ард түмэн, ар тал бий юм шүү гэсэн сэтгэгдлийг ямагт төрүүлж байсныг одоо ч гэсэн тэд дурсдаг. Бид зөвхөн бэлэг, тусламж хүргээд зогсохгүй фронтод тэртээ 1939 оны Халхын голын түүхт өдрүүд шиг хамт тулалдаж байсан юм. Бид 500 мянган агт морьтойгоо фашизмын эсрэг хамтдаа тулалдаж Берлин хүрсэн гайхамшигт ялалтыг бүтээлцсэн.

Хамгийн сүүлийн үеийн тоо баримтаар 500 гаруй монгол хүн Эх орны дайнд их, бага хэмжээгээр оролцож аугаа их ялалтад хувь нэмрээ оруулжээ. Ялалтын баяр бидэнд яагаад чухал вэ? Аугаа эх орны дайны ялалтын үр дүнд бид 1945 оны 8 дугаар сарын 10-ны өдөр чөлөөлөх дайнд оролцож улмаар ялалт байгуулсан ба 1945 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Бүх нийтийн санал асуулгаар Манжийн эрхшээлд орсноос хойш 250 гаруй жилийн дараа тусгаар тогтнолоо олж авсан учир Аугаа Эх орны дайн бидний хувьд хамгийн чухал тэмдэглэлт, түүхэн үйл явдал юм.

Энэ бол хоёр улсын ард түмний хамтын ялалт. Бас бид бүхний хамтын баяр.

**БХШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн дарга, доктор (Ph.D), хошууч Т.СҮХБААТАР**

## ДОКТОРЫН ЗЭРЭГ ХАМГААЛНА

Батлан хамгаалах, Аюулгүй байдлын докторын ажил хамгаалуулах зөвлөлийн хуралдаанаар 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр "Цэрэг, батлан хамгаалах" чиглэлээр Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуулийн докторант, хурандаа Д.Баасандамба "Зэвсэгт хүчний цэргийн сургалтыг боловсронгуй

болгох арга зам", 5 дугаар сарын 20-ны өдөр докторант, хурандаа Л.Баатар "Мотобуудлагын бригадын хориглох байлдаанд ар талын хангалтыг зохион байгуулж явуулах нь", 15-ны өдөр "Аюулгүй байдал судлал" чиглэлээр докторант, хошууч Д.Идэшноров "Үндэсний аюулгүй байдлыг хангахад нийгмийн сэтгэл зүйн

нөлөөллийн шинжилгээ", 18-ны өдөр докторант Х.Түвшинжаргал "Амьдрах орчны аюулгүй байдал, иргэний боловсролын хамаарлын судалгаа", 25-ны өдөр докторант, дэд хурандаа Б.Нэргүй "Үндэсний аюулгүй байдлыг хангахад иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх арга зам" сэдвээр тус тус доктор (Ph.D)-ын зэргийг хамгаалах аж.

## "МОНГОЛ ЦЭРЭГ ЭНХИЙН ТӨЛӨӨ" ДУРСГАЛТ ЦОГЦОЛБОР ...



Даян дэлхийн энх тайвны төлөө Монгол Улсын Зэвсэгт хүчний оруулсан хувь нэмэр, алдар гавьяаг иргэд, залуу хойч үедээ түгээн дэлгэрүүлж, сурталчлан таниулах зорилго бүхий "Монгол цэрэг энхийн төлөө" дурсгалт цогцолборын энхийг сахиулагчдын хөшөөний бүтээн байгуулалтын ажил амжилттай явагдаж байна. Зэвсэгт хүчний ахлагч нарын хандиваар хийгдэж буй тус хөшөөний нээлтийн үйл ажиллагаа Олон улсын энхийг сахиулагчдын өдөр буюу 5 дугаар сарын 29-нд болох аж.

**ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Б.ГАНТӨМӨР**

## УРИАЛГА

Та бүхнийг энэ жил дэлхий даяар онлайн хэлбэрээр явагдаж байгаа "Мөнхөд дурсагдах дайчид" аянд нэгдэхийг уриалж байна.

Халхын голын байлдаан, Чөлөөлөх дайн, Дэлхийн хоёрдугаар дайн, Аугаа Эх орны дайнд оролцож явсан дарга, цэрэг дайчид, дайны хүнд жилүүдэд ар талыг хангаж байсан иргэд зэрэг фашизм болон милитаризмыг дийлж хамтын ялалтад хувь нэмрээ оруулсан хүн бүхний хөрөг зураг, гэрэл зураг, дурсамж бүхий дүрст бичлэгийг нийгмийн сүлжээнд байршуулж тараацгаая!

Ингэснээр өвөг дээдсийнхээ баатарлаг гавьяат үйлсийг найз нартаа өгүүлцгээе!

Ахмад дайчин, дайнд оролцсон төрөл төрөгсөд, найз, нөхдийнхөө хөрөг зургийг барьсан гэр бүлийнхээ гэрэл зураг, дүрст бичлэгийг цахим сүлжээнд #Мөнхөд дурсагдах дайчид, #Бессмертныйполк Монголия, #Бессмертныйполк2020 гэсэн хаштэгтэй бичиж байрлуулаарай.

Мөн нийтэлсэн материалаа "Монгол Улсын мөнхөд дурсагдах дайчид" фэйсбүүк бүлэгт давхар байршуулаарай. Мөн гэр бүлээрээ цугларч, баатарлаг үйлсийн эзэд болсон ахмад дайчдаа дурсан санаж, тэдний тухай үр хүүхдүүддээ ярьж өгнө гэдэгт итгэл төгс байна.

"Үхэшгүй мөнхийн хороо" нь Аугаа Эх орны дайнд оролцсон өвөг дээдсийнхээ зургийг барьж алхдаг хүндэтгэлийн жагсаал ба ОХУ-ын болон бусад улс орнуудын иргэд уг жагсаалыг Ялалтын баярын өдөр зохион байгуулдаг юм. Энэхүү хөдөлгөөн нь 2007 онд ОХУ-ын Тюмень хотод эхэлсэн бөгөөд 2015 оноос эхлэн албан ёсоор Орос орон даяар, цаашлаад олон улсын аян болж өргөжсөн аж. Монгол Улсад "Мөнхөд дурсагдах дайчид" хөдөлгөөнийг Монгол-Орос найрамдлын нийгэмлэг, Оросын нутаг нэгтгүүдийн байгууллагуудын зохицуулах зөвлөл, Монголын Энх тайван, найрамдлын байгууллага, Монголын Ахмадын холбоо зэрэг байгууллага санаачилжээ.

## Хилийн чанадаас

## ДӨРӨВДҮГЭЭР САРЫН МАНЛАЙЛАГЧИД ТОДРОВ



Ш.Баваасан (016) нар шалгарсан бол дэслэгч Д.Олонхүү (ХХЕГ) захирагчийн салааны хамт олон "Тэргүүний салаа"-гаар шалгарсан юм.

Түүнчлэн сарын "Шилдэг офицер"-оор дэслэгч Л.Алтанзул-Од (353), "Шилдэг ахлагч"-аар сургагч ахлагч

Тухайн сард ажил үйлс, авьяас билгээрээ хамт олноо үлгэрлэн манлайлсан цэргийн алба хаагчдаа шалгаруулан "Сарын тэргүүн" болон "Шилдэг"-ээр өргөмжилдөг уламжлалтай билээ. Тэгвэл дөрөвдүгээр сарын "Тэргүүний офицер"-оор дэслэгч Э.Мэндбаяр (123), "Тэргүүний ахлагч"-аар ахлах ахлагч Н.Пунцаг (150), дэд ахлагч С.Цэнд-Аюуш (089), дэд ахлагч Э.Лхагвасүрэн (284) нар шалгарав. Мөн "Тэргүүний эмэгтэй цэргийн алба хаагч"-аар дэд ахлагч З.Баярмаа (337), "Тэргүүний шинийг санаачлагч, бүтээлч цэргийн алба хаагч"-аар дэд ахлагч

Б.Батболд (ҮБХИС), ахлагч Т.Амартүвшин (013), дэд ахлагч Н.Пунцагшан (014), "Шилдэг шинийг санаачлагч, бүтээлч цэргийн алба хаагч"-аар дэд ахлагч С.Цэрэндорж (013), "Шилдэг эмэгтэй цэргийн алба хаагч"-аар дэд ахлагч Э.Цэрэнлхам (065) нар тус тус шалгарлаа.

Ийнхүү эзэмшсэн мэргэжил, хүлээсэн үүрэгтээ эзэн нь байж, эх орон, Зэвсэгт хүчнийхээ нэр хүндийг НҮБ болон мөр зэрэгдэн үүрэг гүйцэтгэж буй бусад улс орнуудын цэргийн алба хаагчдын дунд өндөрт өргөн, монгол цэргийн мөн чанарыг таниуллаа.

## БИЧИЛ ҮЗЭСГЭЛЭН ГАРГАВ

Аугаа Эх орны дайны ялалтын түүхт 75 жилийн ойг тохиолдуулан Монгол цэргийн музей нь Шинэ түүхийн танхимдаа "Монголын ард түмэн: Бүхнийг фронтод, Бүхнийг ялалтын төлөө" үзэсгэлэнг дэглэлээ.

Аугаа Эх орны дайны эхний өдрөөс Монголын төр, засаг, ард түмэн Гитлерийн Германы эсрэг дайн зарлан Зөвлөлтийн ард түмний шударга тэмцэлд нэгдэн орсон түүхтэй. Монголын ард түмэн Зөвлөлтийн Улаан армид сайн дураараа туслах хөдөлгөөнийг олон хэлбэрээр өрнүүлж, "Бүхнийг фронтод", "Бүхнийг ялалтын төлөө" гэсэн уриан доор үзүүлэх тусламжийг улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, үзэл суртлын хүрээгээр тодорхойлон хүнс, хувцас, агт морьд, мал, мөнгө, төгрөг, алт, үнэт эдлэл, зэвсэг, техникээр туслан, захидал илгээх замаар сэтгэл санааны дэмжлэг үзүүлж ирсэн тухай түүхэн мэдээлэл бүхий самбар, биет үзэмрүүдийг дэлгэн харуулснаараа тус үзэсгэлэн онцлогтой юм.

Энэ дайн бол Оросын Холбооны Улс болон Монгол Улсын түүхэнд гүнзгий ул мөрөө үлдсэн хоёр орны ард түмний найрамдлын нэгэн алтан хуудас болон мөнхөрсөн билээ.

**Боловсролын ажилтан-тайлбарлагч Д.БАЯНЖАРГАЛ**



АУГАА ЭХ ОРНЫ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙД

# “МОНГОЛ АРД” НИСЭХ ЭСКАДРИЛЬ ХЭРХЭН ҮҮСЭВ

Зөвлөлтийн Улаан армийн дайчид гитлерийн түрэмгийлэгчдийн эсрэг тулалдаж, фашизмын эзлэн бооллох аюулаас эх орноо цаашлаад дэвшилт хүн төрөлхтнийг авран хамгаалах их тэмцэлд нь хэр чадлаараа хүчин тусалцах Монголын бүх ард түмний өргөн их хөдөлгөөнийг ид өрнүүлсэн он жилүүд байлаа.

“Бүгдийг фронтод”, “Бүгдийг ялалтын төлөө” гэсэн лоозон манай орны улс төр, үзэл суртал, аж ахуй, соёлын байгуулалтын цаг үеийн дайчин зорилт болж, хүн бүхэн чадах, болох бүхнийг ашиглан Зөвлөлтийн Улаан армид элгэн халуун сэтгэл юугаа илэрхийлсэн бэлэг сэлтийг явуулахын тулд хүч чадал, оюун мэдлэгээ хөвчлөн дайчилж байв.

1943 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн БНМАУ-ын Бага хурлын чуулганаар:

1.Фашизмтай тэмцэж байгаа Улаан тугийн одонт “Хувьсгалт Монгол Улс” танкийн тусгай бригадыг дайн дуустал хувцас хунар, хүнсний бүтээгдэхүүнээр бүрэн хангахыг тус улсын хөдөлмөрчин ард түмнээс цуглуулсан хөрөнгөөр гүйцэтгэсүгэй.

2.Монголын хөдөлмөрчин ард түмний хүслийн ёсоор “Монгол Ард” хэмээх нисэх онгоцны эскадриль байгуулахад хөрөнгө хуримтлуулахыг бүх улсын хэмжээнд зохиож, баатарлаг улаан армид манай ард түмний бэлэг болгон шилжүүлж өгсүгэй гэсэн түүхт шийдвэрийг санал нэгтэй баталсан юм.

Энэхүү шийдвэрийн дагуу Зөвлөлтийн Улаан армид туслах хөдөлгөөний өрнөлтийн хоёр дахь том үе шат эхэлсэн байна.

“Монгол ард” гэж нэрлэсний учир бол уг эскадриль нь бүх ард түмний хөрөнгөөр бүтсэн юм гэдэг утга санааг хадгалж байжээ. БНМАУ-ын Бага хурал ийнхүү Улаан армид нисэх эскадрилийг бэлэглэхээр шийдвэрлэсэнээ Зөвлөлтийн ард түмэн, Зөвлөлт Засгийн газарт тусгай илгээлт явуулж баяртайгаар мэдэгдсэн юм.

Эскадрилийг байгуулах хөрөнгө цуглуулах хөдөлгөөн улс орон даяар өрнөж, тэрхүү ариун цагаан тусламжийн фронтод нэмэр хандив оруулах эх оронч бодол хүн бүрийг эзэмдэв. Улаан армид явуулах бэлгийн Төв комисс, түүний аймаг, хот, үйлдвэр, албан байгууллага дахь салбар өдөр шөнөгүй ажиллаж, хувийн бэлэг худалдах дэлгүүр, хоршоо хүмүүсээр дүүрэн байдаг болов.

Үйлдвэрийн газрын хамт олон үйлдвэрлэлийн төлөвлөгөө, фронтод явуулах бэлгийн захиалгыг хугацаанд нь ханган биелүүлэхийн тулд хоногт 14-16 цаг ажиллаж байлаа. Төв, орон нутгийн бүх сонин хэвлэл “Нисэх эскадриль бол баатарлаг улаан армийн агаарын цэргийн хүчинд барих манай хамгийн шилдэг бэлэг мөн”, “Фронтод зориулсан байлдааны нисэх онгоцнуудыг хурдан шуурхай байгуулах” гэсэн уриалга нийтэлж, сонини хуудсанд “Монгол ард” эскадрильд зориулсан тусгай булан нээж тусламжийн фонд, хуримтлалын дүнг өдөр тутам мэдээлэх болов.

1942 онд Зөвлөлтийн ард түмэн, баатарлаг улаан армид явуулах бэлгийн фондоод бүтэн сарын цалин, бас дайн дуустал цалингийн 5-аас 10 хувийг шилжүүлж байх сайн дурын хөдөлгөөн БНМАУ-ын ажилчин, албан хаагчдын дунд өрнөжээ. Тусламжийн фондоод манай орны нийт хүн ам, жирийн ажилчин, малчнаас эхлээд төрийн сайд, олон нийтийн зүтгэлтнүүд цөм хир чинээний хувь нэмрээ оруулцагасан байна.

БНМАУ-ын Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсан 1943 оны 7 дугаар сарын 22-ны өдөр Зөвлөлт Засгийн газрын тэргүүн И.В.Сталинд цахилгаан утас илгээж, нисэх эскадриль байгуулахад зориулан Улаан армид бэлэглэж байгаа 2 сая төгрөгийг хүлээн авахыг хүсээд, “Энэхүү байлдааны онгоцнуудыг Улаан армийн чин зоригт шонхрууд жолоодон, манай “Хувьсгалт Монгол Улс” хэмээх танкийн бригад фашистын дээрэмчидтэй баатарлагаар тэмцэж байгаатай адилаар дайсны амьд хүч, техникийг сөнөөх болтугай” гэсэн монголын хөдөлмөрчдийн захиа даалгаврыг уламжилжээ.

Маргааш нь “Үнэн” сонин “Монгол ард нисэх эскадриль дайсныг бут ниргэг” гэсэн тэргүүн өгүүлэл нийтэлж, түүнд “Монгол ард хэмээх сүрт онгоцнуудаар дайсныг эрэлхгээр устгах улаан армийн чин зоригт олон баатрын үйлсийг монголын ардууд удалгүй цээж дүүрэн баяртай сэтгэлээр сонсох болно” гэж бичсэн байв.

“Монгол ард” эскадрилийн онгоцнуудыг үйлдэж байгуулах ажлыг монголын хөдөлмөрчид хэрхэн яаж санхүүжүүлсэн тухай баримт материал нь одоо ЗСБНХУ-

ын Батлан хамгаалах яамны архивд хадгалаастай байна. Тэрхүү материалаас үзэхэд Зөвлөлтийн армид явуулах бэлэглэлийг эрхэлсэн улсын төв комисс 1943 оны 7 дугаар сарын 31-ний өдөр “Монгол ард” нисэх эскадриль байгуулахад зориулан ЗСБНХУ-ын Сангийн хэрэг эрхлэх Ардын комиссариатын дансанд 2 сая төгрөг (2 628 000 рубль)-ийг гуйвуулжээ.

Үүнтэй холбогдуулан И.В.Сталин 1943 оны 8 дугаар сарын

урлагт сургах талаар маш их хүч хөдөлмөр зориулцаав. Байлдааны шаргуу бэлтгэл нь өдөржин, шөнөжин үргэлжилж байлаа. Хорооны дарга, Зөвлөлт Холбоот Улсын баатар, гвардын хошууч А.П.Соболев “Дасгал сургуульд ядарвал, дайн, тулалдаанд хөнгөн байдаг” гэсэн Суворов жанжны захиа сургаалыг нэг бус удаа сануулж хэлдэг байв. Хорооны даргын байлдааны туршлага, зохион байгуулах чадвар, шийдэмгий зориг болон офицер,

жилд Н.Я.Зенькович нийт 237 удаа байлдааны нислэг хийж, 37 удаа агаарын тулалдаанд оролцож дайсны 11 онгоцыг сөнөөжээ. Энэ завсар 8 одон, 11 медаль, түүний дотор БНМАУ-ын хоёр одонгоор шагнагджээ.

Эскадрилийн дайчин үйл ажиллагаа ид өрнөж байх үеэр БНМАУ-ын Засгийн газрын төлөөлөгчид Москвад хүрэлцэн

багтаж Монгол Улсад 1968-1990 онд “Монгол ард” хэмээх улаан бичигтэй МиГ-17, МиГ-21, МиГ-27К онгоцнуудаар нисэж байжээ.

Дашрамд дурдахад, БНМАУ-ын нэрэмжит 266 дугаар нисэхийн сөнөөгч-бөмбөгдөгч хорооны 4 дүгээр эскадриль буюу МАА-ийн сөнөөгч онгоцны 1 дүгээр эскадриль нэртэйгээр МиГ-15, МиГ-17 онгоцтойгоор 1970 онд



ЗХУ-ын баатар, нисгэгч-бөмбөгдөгч, хошууч А.И.МАЙОРОВ

18-ны өдөр Х.Чойбалсанд тусгай илгээлт явуулжээ. Түүнд:

“БНМАУ-ын Ерөнхий сайд маршал Х.Чойбалсан Танаа

Гитлерийн булаан эзлэгчидтэй баатарлагаар тэмцэж байгаа Улаан армид “Монгол ард” хэмээх байлдааны онгоцны эскадриль байгуулж бэлэглэхэд зориулан хоёр сая төгрөг хуримтлуулан шилжүүлсэн явдалд Танд болон Танаар уламжлан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, ард түмэнд Зөвлөлт Засгийн газрын өмнөөс болон хувиасаа чин зүрхний баяр талархал хүргэе. “Монгол ард” хэмээх байлдааны онгоцны эскадриль байгуулах гэсэн БНМАУ-ын хөдөлмөрчдийн хүсэлт биелэгдэнэ. И.СТАЛИН 1943 оны 8 дугаар сарын 18” гэжээ.

1943 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр ЗСБНХУ-аас БНМАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд И.Иванов тусгай нот бичгээр маршал Х.Чойбалсанд: “БНМАУ-ын Засгийн газраас манай улсыг батлан хамгаалахад зориулан гуйвуулсан мөнгөөр “Монгол ард” хэмээх байлдааны онгоцны эскадриль байгуулсныг энэхүү нот бичгээр Таны сонорт толилуулан мэдэгдье. Фашистын булаан эзлэгчдийг эсэргүүцэн тэмцэж байгаа Зөвлөлтийн ард түмний Эх орны дайны өдрүүдэд Зөвлөлт Холбоот Улсад тусламж үзүүлж байгаа явдалд Зөвлөлт Засгийн газрын өмнөөс Танд болон БНМАУ-ын Засгийн газар, монголын ард түмэнд баяр талархал илэрхийлье” гэж мэдэгджээ.

Ийнхүү 1943 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр “Монгол Ард” эскадриль нь 322 дугаар сөнөөгч нисэхийн дивизийн 2 дугаар гвардын нисэхийн хорооны 2 дугаар эскадриль нэртэйгээр хажуу бөөрөндөө “Монгол Ард” гэсэн тод улаан үсэгтэй цоо шинэ “ЛА-5” хэмээх 12 нисэх онгоцтойгоор байгуулагджээ. Эскадрилийн анхны захирагчаар ЗХУ-ын баатар, гвардын ахмад Н.П.Пушкин томилогдон Монгол, Зөвлөлтийн ард түмний эвдэршгүй найрамдал, ах дүүгийн барилдлагын түүхийн бас нэг гайхамшигт хуудсыг нээсэн “Монгол ард” эскадриль ингэж үүсжээ.

## “МОНГОЛ АРД” НИСЭХ ЭСКАДРИЛЬ ЭХ ОРНЫ ДАЙНЫ ФРОНТОД

Хорооны нэн тэргүүний зорилт нь ойрын өдрүүдийн байлдаанд яаралтай бэлтгэж, хүмүүс болон техникийг бүрэн бүрдэл болгож, нисэгчдийн нислэгийн чадварыг дээшлүүлэхэд оршиж байлаа.

Туршлага, дадлага, эрэлхэг зоригтой нисэгчид Николай Пушкин, Николай Зенькович, Анатолий Калинин, Григорий Бессолицын, Михаил Рябцев нар залуу нисэгчдийг агаарын байлдааны нарийн төвөгтэй

байлдагчдыг халамжлан үздэг хүнлэг чанар нь хамт олныхоо хайр хүндэтгэлийг татаж байлаа. Энэ бүхний ачаар ч гвардын 2 дугаар хороо, дивизээр барахгүй бүх корпусынхаа дотор шилдэг хороонд тооцогдож байлаа.

Тус эскадриль нь Волхов, Калининний болон Баруун фронт, Брянскийн фронт, Балтийн нэгдүгээр, Белоруссийн гуравдугаар фронтод байлдаж Курск, Витебск-Орш, Сандомирийн тулалдаанд оролцож, Беларусь, Литва, Дорнод Прусс, Польш, Герман, Чехословакийн нутгийг чөлөөлөхөд байлдааны үүргээ амжилттай биелүүлж, монголын ард түмний итгэлийг биелүүлсэн билээ. “Монгол ард” эскадриль нь сөнөөгч онгоцны хоёрдугаар хорооны бүрэлдэхүүнд багтан янз бүрийн фронтод гарамгай гавьяа байгуулсан учир ЗХУ-ын Байлдааны гавьяаны улаан тугийн одон болон Суворовын одонгоор шагнагдаж, 1944 оны долоодугаар сард Оршийн нэрэмжит болжээ.

Дайны он жилүүдэд гвардын ахмад Н.П.Пушкин, ахлах дэслэгч Н.Я.Зеньковичийн удирдлагаар гвардчууд нийт 8474 байлдааны нислэг үйлдэж, 399 агаарын тулаанд оролцож, дайсны 327 онгоц мөн олон тооны амьд хүч, техникийг устгасан ба “Монгол ард” эскадрилийн бүрэлдэхүүнд ЗХУ-ын баатар А.Н.Пушкин, А.И.Майоров, М.Е.Рябцев нар тулалдаж байв.

Өдөр, сар улирч, өрсөлдөх тулалдаан үргэлжлэх тусам хүмүүсийн чадвар, туршлага нэмэгдэж, соргог сэргэлэн дайчдыг удирдах тушаалд дэвшүүлэн тавих боломж, шаардлага гарч ирэх нь зүй билээ. 1943 оны 11 дүгээр сард “Монгол ард” эскадрилийн дарга, гвардын ахмад Н.П.Пушкинийг 2 дугаар хорооны нислэгийн бэлтгэл хариуцсан орлогчоор тохоон томилов.

Эскадрилийн удирдлага Н.П.Пушкиний орлогч, гвардын ахлах дэслэгч Н.Я.Зеньковичид шилжлээ. Тэрээр нас залуу ч 97 удаа байлдааны нислэг үйлдэж, 17 удаа агаарын байлдаан хийж, ганцаараа таван нөхдийн хамт дайсны нэг онгоц сөнөөсөн, бас дайсны цэрэг, ачаа бүхий 17 автомашины шумбан дайрч устгасан офицер байлаа.

Байлдааныг чадамгай удирдан, хариуцсан ангийнхаа байлдааны бэлтгэлийг ямагт бүрэн дүүрэн бөгөөд гавшагй, шуурхай байлгаж, бас ганцаараа дайсны таван онгоцыг сөнөөсөн учир 1943 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнагджээ. Н.Я.Зенькович “Монгол ард” эскадрилийг командалж байхдаа байлдааны нислэг бүрийг үр ашигтай болгох талаар маш их мэрийдэг байжээ. Дайны бүх



МиГ-27, Аэродром Налайх

ирж “Монгол Ард” эскадрилийн онгоцнууд хэр зэрэг байлдаж байгаа хийгээд фашистуудыг улам хүчтэй цохихын тулд юу хийвэл зохихыг мэдэх гэж хүсэж байсан нь БНМАУ-ын хөдөлмөрч

иргэдийн Зөвлөлтийн ахан дүүст туслах чин хүслийг илэрхийлж байсан төдийгүй нисэх эскадрилийн зэвсэг, техникийг шинэчлэн сэлбэх, дайны фронтод дайчин нөхдөд дулаан хувцас, хүнсийг тасралтгүй явуулж байсан нь түүхэн баримтад тэмдэгдэн үлджээ.

## ДАЙНЫ ДАРААХ ЖИЛҮҮДЭД

“Монгол ард” нисэх эскадриль нь дайны дараах жилүүдэд Герман, Унгар, Чехословак, Азербайджан, Украин, Монгол зэрэг улсуудад шилжин байрлаж 1945-2014 оны хооронд олон удаа бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөд орсон байна. Энэ хугацаанд тус нисэх эскадриль нь Ла-7, Ла-9, МиГ-15, МиГ-17, МиГ-21ПФ, МиГ-21ПФМ, МиГ-21БИС, МиГ-23БМ (МиГ-27), Су-25 зэрэг онгоцнуудыг чадварлагаар эзэмшжээ.

1968 оны 2 дугаар сарын 7-ны өдөр “Монгол Ард” эскадриль нь гвардын 2 дугаар Оршанскийн хорооны бүрэлдэхүүнээс гарч 266 дугаар сөнөөгч-бөмбөгдөгч нисэхийн хорооны бүрэлдэхүүнд орж ахмад В.Черепановын удирдлагаар

Зэвсэгт хүчний 337 дугаар анги анх байгуулагдаж байсан түүхтэй.

ЗХУ-ын Аугаа эх орны дайны ялалтын 40 жилийн ойд зориулан 1985 онд “Монгол ард” нисэх

хөдөлмөрч иргэдийн Зөвлөлтийн ахан дүүст туслах чин хүслийг илэрхийлж байсан төдийгүй нисэх эскадрилийн зэвсэг, техникийг шинэчлэн сэлбэх, дайны фронтод дайчин нөхдөд дулаан хувцас, хүнсийг тасралтгүй явуулж байсан нь түүхэн баримтад тэмдэгдэн үлджээ.

эскадрилийн хөшөөг Улаанбаатар хотод босгосон байна.

266 дугаар нисэхийн сөнөөгч-бөмбөгдөгч хороо нь 1990 онд Степь (Чита) аэродромд шилжин байрлаж БНМАУ-ын нэрэмжит дайрагч нисэхийн хороо болон өөрчлөгдсөн. Энэ үеэс эхлэн дайрагч Су-25 онгоцон дээр давхиж буй морьтой дайчны зураг бүхий эмблемийг хэрэглэж эхэлсэн байна.

2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 412 дугаар нисэхийн бааз нь 120 дугаар дайрагч авиацийн холимог тусгай хороо (Аэродром Домна, Чита хот) болон өргөтгөн зохион байгуулагдаж түүний бүрэлдэхүүнд алдарт “Монгол Ард” эскадриль үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус хороо (3 эскадрильтэй)-ны зэвсэглэлд Су-30М, Су-34, Су-25




Монгол Ард 2 дугаар эскадрилийн Дайрагч Су-25 /ОХУ, Чита хот, аэродром Домна/

Житомирск мужийн Овруч /Украйн/ аэродромд шилжин байрласан байна.

1968 оны 3 дугаар сард 266 дугаар сөнөөгч-бөмбөгдөгч нисэхийн хороо нь Байгалийн чанад дахь “Монгол Ард” эскадриль нисэхийн хороо нь 1968 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Налайх аэродромд шилжин ирж, майханд

онгоцнууд байдаг бөгөөд тус хорооны 2 дугаар эскадриль нь дайрагч Су-25 онгоцтой. Эскадрилийн захирагчаар дэд хурандаа Э.В.Дикунар ажиллаж байна.

“Монгол Ард” эскадриль үүсэн байгуулагдаж фашизмын эсрэг баатарлагаар тулалдсан түүхэн цаг хугацаанаас хойш 77 жил өнгөрч байна. Аугаа их ялалтын өдрийг ойртуулахад монголын ард түмнээс овоглосон агаарын зоригт шонхрууд өөрийн хувь нэмрээ оруулсан нь дамжиггүй. Тэдний түүхэнд тодоос



байрлаж байсан байна. Энэ үеэс ЗХУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор 266 дугаар сөнөөгч-бөмбөгдөгч нисэхийн хороог БНМАУ-ын нэрэмжит болгосон байна. “Монгол Ард” 2 дугаар эскадриль нь 266 дугаар нисэхийн сөнөөгч-бөмбөгдөгч хорооны бүрэлдэхүүнд

тод бичсэн гэгээн үйлстэй ариун мөр хоёр орны ард түмний найрамдал, дайчин нөхөрлөлийн бэлгэ тэмдэг болон мөнхөд орших болно.

**Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсийн нисэхийн-ерэндийн инженер, ахмад Э.МӨНХ-ЭРДЭНЭ**

АУГАА ЭХ ОРНЫ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙД

# МОНГОЛЫН АРД ТҮМНЭЭС ЭХ ОРНЫ ДАЙНЫ ЖИЛҮҮДЭД

## ДАЙНЫ ЭХНИЙ ӨДРӨӨС ЗӨВЛӨЛТ УЛСЫН ХОЛБООТОН

Монголын төр, засаг, ард түмэн өөрийн эх орны хөгжил, дэвшил, тусгаар тогтнолыг Зөвлөлт Холбоот Улстай шууд холбон үзэж байсны хувьд дайн эхэлсэн өдрөөс Гитлерийн Германы эсрэг Зөвлөлтийн ард түмний хийж буй ариун тэмцэлд нэгдэн орсон юм. Зөвлөлтийн ард түмний Аугаа Эх орны дайн эхэлсэн тэр өдөр БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид, МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурал болж ЗХУ-д Гитлерийн



МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчид, БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурал

Герман халдан довтолсныг эрс жигшин эсэргүүцэж байгаагаа мэдэгдэв. Үүний хамт Монголын ард түмэн Зөвлөлтийн ард түмэнтэй гар гараасаа барилцан явж, Монгол-Зөвлөлтийн 1936 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн Харилцан туслалцах тухай протокол гэрээгээр хүлээсэн үүргээ үнэнчээр биелүүлэхэд бэлхэн байгаагаа илэрхийлээд, ЗХУ-д бүх бололцоогоор туслахыг ард түмэндээ уриалсан юм. Ийнхүү Монгол Улс эх орны дайны үед ЗХУ-ын талд баттай зогсож, фашизмын эсрэг эвсэлд оролцох байр сууриа дэлхий дахинд эн тэргүүнд албан ёсоор зарласан анхны улсын нэг болжээ. Монголын ард түмэн Зөвлөлтийн Улаан армид сайн дураар туслах хөдөлгөөнийг энэ цаг үеэс эхлэн олон хэлбэрээр өрнүүлж, "Бүхнийг ялалтын төлөө", "Бүхнийг фронтод" гэсэн уриан дор дайны жилүүдэд ажиллаж, амьдарч эхэлжээ. Энэхүү тусламжийг улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, үзэл суртлын хүрээгээр тодорхойлж болох ба хэлбэрийн хувьд биеэр оролцсон, хүнс, хувцас, агт морьд, мал, төгрөг, мөнгө, алт, үнэт эдлэл, зэвсэг, техникээр тусалсан, захидал, илэрхийлэлт бичсэн зэргээр сэтгэл санааны дэмжлэг үзүүлсэн хэмээн ангилан үзэж болно.

Үйлдвэрийн ажилчид төлөвлөгөөгөө 400 хувиас доошгүйгээр давуулан биелүүлэх, ээлжийн амралтаа авахгүй ажиллах, өдөр бүр 2-5 цаг илүү ажиллах,



амралтын өдрөөр ажиллаж Улаан армид туслах хөрөнгө хуримтлуулах санаачилга гаргасныг бүхий л үйлдвэрийн ажилчид дэмжин амралтын өдрүүдэд ажиллах явдал улмаар нийтлэг үзэгдэл болжээ. Зөвлөлтийн ард түмэнд туслах хөдөлгөөн ажилчин, малчин, сэхээтэн, цэргийн алба хаагчид болон өндөр настан, сургуулийн сурагчид, үндсэндээ манай орны нийгмийн бүхий л давхаргын дунд аяндаа, сайн дураар үүссэн ба олон түмнийг хамрах болов. Ард түмний дунд ийм хөдөлгөөн өрнөсөнтэй холбогдуулан 1941 оны 9 дүгээр сард Сайд нарын Зөвлөлийн дэргэд Улаан армид бэлэг хуримтлуулах, хүргэх ажлыг эрхлэн зохион байгуулах "Бэлэглэлийн төв комисс"-ыг байгуулж, даргаар нь жанжин Д.Сүхбаатар агсны гэргий, МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга С.Янжмааг томилон ажиллуулжээ. Комиссын салбарууд 18 аймаг, сумд, үйлдвэр, албан газруудад мөн байгуулагдав.

Энэ комиссын ажлын нэг хэсэг нь Зөвлөлтийн Улаан армид зориулж бэлэг бэлтгэх явдал байсан бөгөөд ард түмнээс цугларсан бэлгийг тусгай цуваа болгон илгээж байв.

## ЗӨВЛӨЛТИЙН УЛААН АРМИД ХҮРГЭСЭН БЭЛГИЙН ЦУВАА

Улаан армид зориулан Монголын ард түмний хуримтлуулсан бэлгийн анхны цувааг Октябрийн хувьсгалын 24 жилийн ойг тохиолдуулан 1941 оны 11 дүгээр сард илгээжээ. Түүнд багтсан зүйлийг Аж үйлдвэрийн комбинат, үйлдвэр, хоршооллын ажилчид 1941 оны төлөвлөгөөнөөс гадуур, илүү цагаар буюу ням гараг, ээлжийн амралтаараа ажиллан бүтээсэн бөгөөд нийт 15000 цэргийг хувцаслах нэхий дээл, эсгий гутал,



Бэлгийн цувааны галт тэрэг хөдлөхөд бэлэн боллоо



Төр, засгийн удирдагчид бэлгийн бараатай танилцаж байгаа нь

үстэй бээлий, нэхий хантааз, цэрэг бүс, 6000 ширхэг ноосон цамц, 440 нэхий хөнжил зэргийг илгээжээ. Энэ нь тухайн үеийн ханшаар 1,813,515 төгрөгийн үнэ бүхий зүйл байсны зэрэгцээ бэлнээр 587,000 төгрөгийг Зөвлөлтийн "Улсын банк"-д шилжүүлжээ.

Анхны энэ цуваа нь чухам хэдэн вагоноос бүрдсэн тухай баримт олдоогүй бөгөөд бэлгийг Куйбышев хот руу илгээсэн байна. Цувааг хүлээлгэн өгөхөөр Монголын талаас албан ёсны төлөөлөгч томилогдоогүй ажээ.

Зөвлөлтийн Улаан армийн 24 жилийн ойг тохиолдуулан 1942 оны 2 дугаар сард бэлгийн хоёр дахь цувааг илгээв. Энэхүү цувааг БНМАУ-ын Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч С.Лувсан, МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Бэлэглэлийн төв комиссын дарга С.Янжмаа, Монгол Ардын хувьсгалт цэргийн хошууч (БНМАУ-ын баатар, хурандаа) П.Шагдарсүрэн, яруу найрагч Л.Цэнд-Очир, сайн малчин Б.Пунцаг, партизан Д.Дамба, ажилчин Баасан, БНМАУ-аас ЗСБНХУ-д суугаа Элчин сайд Ж.Самбуу нарын арваад хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид армийн генерал Г.К.Жуковын командалсан Баруун фронтын 49 дүгээр армийн их бууны ба буудлагын дивиз, хороодын дайчдад гардуулан өгчээ. Гучин долоон вагон тэрхүү бэлгийн цуваанд 148,1 тонн төрөл бүрийн мах, 8 тонн хиам, 10 тонн төрөл бүрийн боов, боорцог, 4,5 тонн тос, 8000 литр архи хийгээд 5,5 сая ширхэг папирос, 2750 хос эсгий гутал, 2706 дах, 4100 дулаан хантааз, 1320 богино нэхий дээл, 6290 хос бээлий, 4500 гэрийн эсгий, 2000 суран бүс болоод савхин гутал, хүүзүүний ороолт, хөвөнтэй хувцас, чихэр, лаазтай сүү багтжээ. Түүний нийт дүн нь 7,187,140 төгрөг болжээ.

1942 онд Октябрийн хувьсгалын 25 жилийн ойг тохиолдуулан бэлгийн гурав дахь цувааг мөн оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Наушкаас хөдөлгөн БНМАУ-ын Ерөнхий сайд маршал Х.Чойбалсангийн ахалсан нам, улс, олон нийтийн байгууллагын зүтгэлтэн, аж үйлдвэр, соёл, шинжлэх ухааны 40-өөд ажилчин, ажилтнаас бүрдсэн томоохон бүрэлдэхүүн хүргэжээ. Монголын ард түмний чин сэтгэл, цаг наргүй хөдөлмөрөөр бүтсэн нийт 236 вагон тэрхүү бэлгийн зүйлст: богино нэхий дээл 30115, эсгий гутал 30500 хос, үстэй бээлий 31257, үстэй хантааз 31090, цэрэг бүс 33300, ноосон цамц 2290, нэхий хөнжил 2011, дах 3050, эсгий гэр 150, гэрийн эсгий 2428, бусад гутал (үстэй сөөхий, цагаан ултай) 2575 хос, эмнэлгийн шаахай 7158 хос, казах эмээл 600, мах 316 тонн, зээрийн мах 26758 ширхэг, тос 92 тонн, хиам 84,8



Бэлгийн цувааны галт тэрэг Москвад ирлээ

тонн, чанамал жимс 12954 кг, чихэр 36900 кг, жигнэмэг, боовны зүйл 70400 кг, эдийн саван 50600 кг зэрэг орсон байна. Мөн савхин дээл 150, торгон савхин гутал 150 хос, ажлын савхин гутал 300 хос, цаначны малгай 900, цагаан архи 480 хайрцаг, бичгийн дугтуй 56050, өврийн дэвтэр 27875, нийтийн бэлэг 127 авдар, хувийн бэлэг 22176, тэрчлэн цаг, хутга зэрэг хүний хэрэглээний маш олон төрлийн зүйлс багтжээ. Бэлгийн нийт үнэ нь 9,252,340 төгрөг болжээ.

Энэхүү цуваа нь дайны үед явуулсан цуваануудын том нь бөгөөд Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсан, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга Г.Бумцэнд, Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядын жанжин Ч.Мижид, МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Ч.Сүрэнжав нараар толгойлуулсан 4 хэсэгт хуваагдан Баруун, Баруун хойд, Волоховын ба Калининний фронтод гардуулан өгчээ.

Улаан армийн 25 жилийн ойд зориулсан бэлгийн ээлжит дөрөв дэх цувааг 1943 оны 3 дугаар сарын 1-ний өдөр явуулжээ. МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн



бичгийн дарга Ю.Цэдэнбалын ахалсан энэхүү цуваанд: 12000 хос эсгий гутал, 12000 хос савхин гутал, 3000 хос ботинк, нисэгчийн гутал 500 хос, шаахай 1000 хос, шинель 10000, хөвөнтэй өмд, цамц 3066, морин цэргийн эмээл 1000, цэрэг бүс 10500, эсгий гэр 38, унадаг дугуй

628 ба зүйл бүрийн хувцас, хөнжил, сахлын машин, хутга, тамхи оролцуулсан 132 ширхэг бэлэг, нийт 205 тонн хүнсний зүйл, зээрийн мах 16745, зэрлэг гахайн мах 715, ятуу шувууны мах 18985, саван 30 тонн, улаан архи 33 торх зэргээс гадна хувийн бэлэг 16973-ыг тус тус явуулсан бөгөөд цувааг хоёр хэсэгт хуваан зохион байгуулж, Ю.Цэдэнбал ба БНМАУ-ын Цэргийн явдлын яамны сайдын орлогч, корпус командлан захирагч Ж.Лхагвасүрэн нараар удирдуулсан, тус бүрдээ арваад хүнтэй төлөөлөгчдийн хэсэг Баруун фронтын 20, 61 дүгээр армийн дивиз, Москвагийн ойролцоох алсын нислэгийн хүнд бөмбөгдөгч онгоцны гвардын 1 дүгээр дивиз, Төв фронтын танкийн армийн нэгтгэл, ангиудад гардуулжээ.

Тав дахь удаагийн бэлгийн цувааг 1943 оны 11 дүгээр сарын эхээр Зөвлөлтийн Улаан армид илгээжээ. Бэлгийн цувааг БНМАУ-ын Ерөнхий сайдын орлогч Б.Ламжав, Н.Жагварал нарын арав шахам хүнтэй төлөөлөгчид фронтод хүргэсэн бөгөөд уг цуваа нь "Хувьсгалт Монгол" танкийн бригадэд зориулагдсан ажээ. 32 вагоноос бүрдсэн энэ цуваанд цэргийн богино нэхий дээл, шинель, үстэй хантааз тус бүр 1200 ширхэг, эсгий болон савхин гутал, үстэй бээлий тус бүр 1200 хос, үхэр, хонины мах 58 тонн, зээрийн мах 44 тонн, гахайн мах 15,6 тонн, хиам 15,9 тонн, цөцгийн тос 15,6 тонн, нарийн боов 13,1 тонн болон 4000 орчим хувийн бэлэг багтжээ. Мөн 1944 оны 5-10 дугаар сард албан байгууллагуудаас 8,810,784 төгрөг, ард иргэдээс 674,001 төгрөг Төв комисст цуглажээ.

Зургаа дахь удаагийн бэлгийн цуваа нь 1945 оны 1 дүгээр сард фронтод хүрсэн бөгөөд түүнд эсгий гутал 31000, янз бүрийн савхин гутал 1600, цэрэг нэхий дээл 20000, шинель 2000, ямаан дах 1010, дарга, цэргийн суран бүс 22000, үстэй хөнжил 870, эмнэлгийн шаахай 3000, хүүзүүний ороолт 2000, ноосон бээлий 2486, гэр 6, эсгий 5408 метр, эдийн саван, махор тамхи 83 гаруй тонн, малын ба гахайн мах 158 тонн, хиам, шар тос, чанамал жимс бүгд 80 шахам тонн, зээрийн мах 14424, шувууны мах 2364, сүлжмэлийн зүйл ширхэг буюу хосоор 4920 зэрэг нийт 36 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, хувийн бэлэг 12460 багтсан 127 вагоноос бүрдэж байв. Цувааны 102 вагоныг Наушкаас, 25 вагоныг Чойбалсан станцаас тус тус илгээсэн бөгөөд нийт үнэ нь 8 сая төгрөг байжээ. Цувааг МАХН-ын Төв хорооны нарийн бичгийн дарга С.Янжмаа, БНМАУ-аас ЗХУ-д суугаа Элчин сайд Ж.Самбуу нарын төлөөлөгчид Украины 1 дүгээр фронтын төлөөлөгчийг Москва хотноо урин ирүүлж хүлээлгэн өгчээ.

## ФРОНТОД БЭЛЭГ ХҮРГЭСЭН ЭМЭГТЭЙН ДУРСАМЖААС

1942 онд Октябрийн хувьсгалын 25 жилийн ойг тохиолдуулан бэлгийн гурав дахь цувааг хүргэх төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Дундговь аймгаас оролцсон, эдүгээ Дундговь аймгийн Сайхан-Овоо суманд амьдарч, хойч үеийнхэнд дурсамжаа хүүрнэн суугаа Сүрэнхорын Цэгмэд гуай сурвалжлагчтай ярьсан дурсамждаа: БНМАУ-ын Ерөнхий сайд маршал Х.Чойбалсангийн тэргүүлсэн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга Г.Бумцэнд, МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Ч.Сүрэнжав, Ардын сайн дурын морьт отрядын жанжин Ч.Мижид нараас гадна үйлдвэрийн тэргүүний ажилчин, тэр үеийн 18 аймгийн 15-аас нь малчин төлөөлөгч бүгд дөчөөд хүн орсноос би хамгийн залуу нь байлаа. Бид 1942 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр галт тэрэгээр гараад 9 хоног явж Москва хотод очиход Улаан талбай, Их театр, музей зэрэг нь бөмбөгдөлтөд өртсөн аймшигтай дүр зураг харагдаж байв. Төлөөлөгчдийг 4 хэсэгт хуваан очих фронтуудад хуваарилахад би Ч.Сүрэнжав даргын тэргүүлсэн хэсэгт багтаж Свердловскийн фронтод очсон.



Фронтод бэлэг хүргэсэн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Дундговь аймгаас оролцсон малчин С.ЦЭГМЭД

Фронтонд ид байлдаан болж дарийн утаа үнэртэн их бууны сумны тэсрэх чимээ нүргэж, сум шунгинан цочирдмоор байсан ба биднийг нуувчинд оруулж байлаа. Энэхүү түүхэн үйл явдалд оролцсон их хувь заяагаараа бахархдаг. Манай төлөөлөгчид авч очсон нэхий дээл, шинель, эсгий гутал, бээлий, саван, боодолтой бэлэг зэргээ Улаан армийн дарга, цэргүүдэд гардуулж өгөөд Москва хот руу буцаж ирсэн. 1943 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр "Хувьсгалт Монгол Улс" танкийн цувааг шилжүүлж өгөх ёслол болоход би Дундговь аймгийн нэртэй танкийг ЗХУ-ын баатар Иван Степанович Носовт шилжүүлж өгсөн ба энэхүү танкийг бүтээхэд миний нутагтаа байхдаа хандивласан 1000 төгрөг орсон гэж боддог. Энэ үед Сүрэнжав дарга, Одсүрэн бид гурвыг танканд оруулж их бууны суман дээр нь бичиг, тэмдэг хийлгээд буудаж үзүүлсэн. Маргаан нь "Монголчуудын буудсан их бууны сум 30 орчим фашистыг устгажээ" гэсэн гарчигтай мэдээ бүхий сонин авчирч өгсөн.

Монголын төлөөлөгчдийг 1943 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Кремльд И.В.Сталин хүлээж авах болоход биднийг халуун ус, үсчинд оруулаад шинэ дээл, Монголоос явах үед олгосон хромон савхин гутал өмсгөсөн юм. И.В.Сталин хүн бүртэй гар барьж мэндлээд энэ хүлээн авалт дээр "ЗХУ-д большевикууд бидний хүч бүх үндэстэн, ард түмэнтэй тогтоосон найрамдалд тулгуурладаг. Бидний дайсан сонгосон үндэстний тогтоосон ноёрхолд тулгуурладаг учир сул байна. Манай ард түмний, бидний анд нөхөд холбоотнуудын хүч нь бүх үндэстний найз, нөхөрлөлд байгаа юм. Монголчууд бидэнд дайны эхний өдрөөс тусалсан, тусалсаар байгаад бид талархлаа илэрхийлж байна. ЗХУ-д бүх ард түмэн адил тэгш эрхтэй улсуудын

# ЗӨВЛӨЛТИЙН УЛААН АРМИД ҮЗҮҮЛСЭН ТУСЛАМЖ

дотор анхдагч гэж байна, тэр нь энэ дайны бүх зовлон, хүнд хүчрийг үүрсэн оросын ард түмэн” гэж хэлж байсныг санаж байна.

Зөвлөлтийн Улаан армид хандиваа өгч, фронтод бэлэг хүргэсэн намайг ЗХУ, ОХУ мартдаггүй, олон удаа бэлэг ирүүлж, мотоцикл хүртэл бэлэглэж байлаа. Аугаа Эх орны дайны ялалтын 40 жилийн ойн медалиас эхлээд 70 жилийн ой хүртэлх бүх ойн медалиар шагнасан. Одоо би нас 97 хүрч байгаа ч сэтгэлээрээ залуу байна гэж ярьсан юм.

## ТАНКИЙН ЦУВАА, НИСЭХ ЭСКАДРИЛЬ БЭЛЭГЛЭВ

Монголын ард түмний хөрөнгөөр байлдааны зэвсэг, хэрэгсэл бэлтгэж өгөх нь тусламжийн онцгой чухал хэлбэр бөгөөд энэ тухай Монгол ардын хувьсгалт цэргийн санаачилгыг Монголын төр, засаг дэмжиж 1942 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр хуралдсан БНМАУ-ын Бага Хурлын 25 дугаар хуралдаанаас “Хувьсгалт Монгол Улс” нэртэй танкийн цувааг байгуулж, Зөвлөлтийн баатарлаг Улаан цэрэгт бэлэглэх, уг танкийн цувааг байгуулах хөрөнгийг хуримтлуулах ажлыг зохиохыг Засгийн газарт даалгасан тогтоол гаргажээ. Үүний дагуу манай улсын Засгийн газраас 2,5 сая төгрөг, 300 кг алт, 100,000 америк долларыг 1942 оны 2 дугаар сард ЗХУ-ын Гадаад худалдааны банканд урьдчилан шилжүүлсэн ба мөн оны 1-7 дугаар сард ард олноос 2 сая орчим төгрөг цугларсан байв.

Энэ бүхний үндсэн дээр танкийн бригадыг ЗХУ-д үйлдвэрлэсэн “Т-34”, “Т-70” загварын 53 танкаар бүрдүүлэн байгуулж, 1943 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр Москвагаас холгүй орших танкийн 112 дугаар



“Хувьсгалт Монгол Улс” танкийн цувааг хүлээлгэн өгч байна

бригадын бүрэлдэхүүнд Монголын ард түмний бэлгийн гурав дахь ээлжийг хүргэж очсон маршал Х.Чойбалсан тэргүүтэй төлөөлөгчид хүлээлгэн өгчээ. Танк бүрийн цамхаг дээр оросоор “Революционная Монголия” (“Хувьсгалт Монгол Улс”) хэмээн бичиж, харин дээд захаар нь “МАХН-ын Төв Хорооноос”, “БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдээс”, “БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс” болон 18 аймгийн ардуудаас, “Аж үйлдвэрийн комбинатын ажилчин, албан хаагчдаас”, “Монголын эмэгтэйчүүдээс”, “Үйлдвэрчний эвлэлээс”, “Хувьсгалт залуучуудын эвлэлээс”, “Партизануудаас” гэх мэтээр тусгай нэртэй байсан бөгөөд гол танкууд нь “Д.Сүхбаатар”, “Х.Чойбалсан”, “Хатанбаатар Магсаржав”, “Г.Бумцэнд” хэмээн нэрлэгдэж байжээ. “Хувьсгалт Монгол Улс” танкийн бригад нь Курскийн дэргэдэх тулалдаанд оролцож гарамгай гавьяа байгуулсан учир “Гвардын” гэдэг хүндэт цол хүртсэн ба улмаар БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1943 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 65 дугаар хурлын тогтоолоор БНМАУ-ын Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнагджээ. Дараа нь 1944 оны 1 дүгээр сард Бердичев хотыг дайран эзлэх үед баатарлагаар тулалдсан учир тус хотын нэртэй болгожээ.

“Хувьсгалт Монгол Улс” гвардын танкийн 44 дүгээр бригад нь Москвагийн дэргэдээс аян дайны түүхэн замналаа эхэлж, Берлиний ерөнхий давшилтад оролцож байлдааны үүргээ гарамгай биелүүлсний учир



“Хувьсгалт Монгол Улс” цувааны танкчид

ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн зарлигаар Лениний, Кутузовын, Улаан тугийн, Суворовын, Богдан Хмельницкийн, Улаан таван хошуу одон болон БНМАУ-ын Байлдааны гавьяаны улаан тугийн одон, 1964 онд Сүхбаатарын одон зэрэг хоёр улсын төрийн дээд шагналыг хүртэж, бригадын 16 танкчин ЗХУ-ын баатар цолоор, тэднээс захирагч, хурандаа И.И.Гусаковский хоёр удаагийн баатар цолоор, дарга, байлдагч 7770 хүн Зөвлөлт, Монгол, Польшийн одон, тэмдгээр тус тус шагнагджээ. Тус анги нь дайны дараа БНАГУ дахь Зөвлөлтийн цэргийн бүлэглэлд байгаад 1990-ээд оны эхнээс ОХУ-ын Москвагийн (одоогийн Баруун) цэргийн тойргийн бүрэлдэхүүнд Владимир хотод байрлаж Сүхбаатарын нэрэмжит Бердичевийн гвардын танкийн сургуулийн 44 дүгээр хороо нэртэйгээр танкчин дайчдыг сургаж бэлтгэж байгаа болно.

Монголын ард түмнээс Зөвлөлтийн Улаан армид бэлэглэсэн бас нэг байлдааны техник бол “Монгол ард” нисэх онгоцны эскадриль билээ. “Монгол ард” эскадрилийг байгуулах тухай шийдвэрийг 1943 оны 3 дугаар сард болсон Улсын Бага хурлын 26 дугаар хуралдаанаас гаргаж хэрэгжүүлсэн юм. Монголын ард түмэн “Фронтод зориулан байлдааны нисэх онгоцны эскадрилийг хурдан шуурхай байгууль”



“Монгол ард” нисэх эскадрилийн онгоц

уриан дор шаардагдах хөрөнгийг 4 сарын хугацаанд хуримтлуулжээ. 1943 оны 7 дугаар сарын 22-ны өдөр Бэлэглэлийн төв комиссоос “Монгол ард” нисэх онгоцны эскадрилийг байгуулахад зориулсан 2,628,000 төгрөгийг ЗХУ-ын Санхүүгийн Ардын комиссарын газрын дансанд шилжүүлсэн байна. Монголын ард түмний хөрөнгөөр байгуулагдсан “Ла-5” загварын 12 нисэх онгоцоос бүрдсэн “Монгол ард” нисэх онгоцны эскадрилийг дэслэгч генерал А.С.Благовещенскийн командалсан сөнөөгч онгоцны 322 дугаар дивизийн гвардын 2 дугаар хороонд Смоленск мужийн төмөр замын “Вязовая” өртөөний ойролцоох хээрийн аэродромд 1943 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр гардуулжээ.



Элчин сайд Ж.САМБУУ “Монгол ард” эскадрилийн нисгэгчдийн хамт

Улаан тугийн одонт Орловын нисэхийн 2 дугаар хорооны бүрэлдэхүүн дэх тус эскадриль нь Волхов, Калининний болон Баруун фронт, Брянскийн фронт, Балтийн нэгдүгээр, Белоруссийн гуравдугаар фронтод байлдаж Курск, Витебск-Орш, Сандомирин тулалдаанд оролцож, Беларусь, Литва, Дорнод Прусс, Польш, Герман, Чехословакийн нутгийг чөлөөлөлцөн байлдааны үүргээ амжилттай биелүүлснээр Монголын ард түмний итгэлийг биелүүлсэн юм. “Монгол ард” эскадриль нь сөнөөгч онгоцны 2 дугаар хорооны бүрэлдэхүүнд багтан янз бүрийн фронтод гарамгай гавьяа байгуулсан учир ЗХУ-ын Байлдааны гавьяаны улаан тугийн одон болон Суворовын одонгоор шагнагдаж, 1944 оны 7 дугаар сард Оршийн нэрэмжит болжээ.

1960-аад оны дундаас 1990-ээд оны эхэн хүртэл БНМАУ-ын нутагт байрлаж байсан Зөвлөлтийн цэргийн бүрэлдэхүүнд байсан ЗХУ-ын 5 одонт нисэхийн 266 дугаар хороо нь “Монгол ард” эскадрилийн залгамжлагч бөгөөд 1990 онд Өвөрбайгалийн “Степь” нисэх буудалд шилжин байрлаж 1995 оноос Улаан тугийн одонт, БНМАУ-ын нэрэмжит дайрагч онгоцны тусгай хороо болон өөрчлөн зохион байгуулагджээ. Одоо тус эскадриль Өвөрбайгалийн хязгаарын Читийн район дахь Домнад байрладаг 412 дугаар нисэхийн баазын бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэж байна.

Монголын ард түмний хөрөнгөөр байгуулж Улаан армид бэлэглэсэн “Хувьсгалт Монгол Улс” танкийн бригад, “Монгол ард” нисэх эскадрилийн бие бүрэлдэхүүний дайны жилүүдийн хангалт, техникийн засвар, шинэчлэлд зориулж Монголын Засгийн газраас 1943 оны 12 дугаар сар, 1944 оны 4 дүгээр сар, 1945 оны 1 дүгээр сард гурван удаа тус бүр 2 сая төгрөг шилжүүлж байжээ.

## МОНГОЛ МОРЬД ФРОНТОД

Эх орны дайны фронтоос 6-7 мянган километр алслагдсан гүн ар талд Монголын ард түмэн бүхий л бололцоогоо дайчлан хөдөлмөрлөж, Зөвлөлтийн Улаан армид туслах олон хэлбэрийн ажлыг өрнүүлсний дүнд нийтдээ 435 сая төгрөгийг үнэ бүхий хувцас, хүнс, эд материалын зүйл ба 300 орчим кг алтыг биетээр өгсний зэрэгцээ Зөвлөлтийн Улаан армид үзүүлсэн томоохон тусламж нь агт морьд нийлүүлсэн явдал байлаа. Дайн эхлэхэд Улаан арми 526,4 мянган морьтой, 1941 оны 9



Малчин ардууд фронтод морьдоо бэлэглэж байна

дүгээр сард 1 сая 324 мянга болсон ч зарлага ихтэй, тооцоогоор нэг удаагийн хэрэглээнд шаардлагатай тоо 1,9 сая байжээ. Цэрэгт шатахуун хүргэж амжихгүй, хүрэлцэхгүй байх тохиолдолд авто, хуяг техник зогсдог бол агт морьд нь бие бүрэлдэхүүн, артиллерийн зэвсэг, цэргийн хэрэгцээний бусад ачаа тээлтийг замтай, замгүй газраар ямар ч цаг улиралд тасралтгүй тээдэг, заримдаа хүнсэнд хэрэглэж болдогоруу давуу талтай.

МАХН-ын Төв хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл 1942 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Малчдаас агт морьд тогтоосон үнээр худалдаж авах тухай тогтоол гаргаж, малчин ардуудыг фронтод морь нийлүүлэх, бэлэглэхийг уриалан “Шилдэг морьдоо фронтод” хөдөлгөөнийг өрнүүлжээ. Үүний дагуу морь бэлэглэх ажил өрнөж адуутай нь шилмэл морьдоо өгч, адуугүй нь бусдаасаа худалдан авч бэлэглэж байжээ. Аймгуудад агт авах байрыг Дорнодод-3, Хэнтийд-4, Төвд-5, Завханд-2, бүгд 14 газар байгуулснаар зарим жил нь зудтай байсан ч энэ ажил орон даяар идэвхтэй үргэлжилж 1942 онд 215 сум, 1943 онд 183 сум, 1944 онд 202 сум агт нийлүүлэх төлөвлөгөөгөө бүрэн биелүүлжээ. Дайны жилүүдэд Монголоос 485,000 морийг улсаас тогтоосон үнээр Зөвлөлтөөс авсан зээлийг хаах журмаар өгч, 32,500 гаруй шилдэг хүлгийг бэлэглэн



Монгол морьд дайны замд

бүгд 517,500 агт морьд фронтод нийлүүлжээ. Монгол морьд морин цэргийн 7 корпусын хэрэгцээг хангаж бүх фронтын замаар давшиж Москвагаас Берлин хүрсэн түүхтэй. Хагас зэрлэг, бие багатай ч арчилгаа, тэжээл шаарддаггүй, тэвчээр хатуужилтай, урт насалдаг, зоримог, шаламгайгаараа европ үүлдрийн морьдоос давуугаараа цэрэг дайчдын дуртай, хайртай унаа нь болж Зөвлөлтийн танктай хамт Берлин хүрсэн тухай Зөвлөлтийн жанжин, армийн генерал И.А.Плиев хожим нь дурсаж бичсэн байдаг. Дайнаас амьд үлдсэн монгол морьд ч шинэ эзэддээ ашиг, эдэлгээгээ өгч байжээ. Оросын нийтлэлч А.Волынец манайхаас агт морьд нийлүүлснийг “Монголчууд бидэнд нэн цаг үеэ олсон өөр сонголтгүй морьдын “ленд-лийз”-ийг хийж, тухайн төрлийн байлдааны техникийн дутууг нөхөн гүйцээсэн юм. Монголын “ленд-лийз” зөвхөн морьдоор хязгаарлагдаагүй дэлхийн хамгийн баян том орон АНУ 665 мянган тонн махан консерв нийлүүлсэн байхад өлөн зэлмүүн 800 мянгахан монголчууд 500 мянган тонн мах нийлүүлсэн юм” гэж дайны үеийн Америкийн “ленд-лийз” хөтөлбөртэй харьцуулсан байдаг нь зүгээр ч нэг зүйрлэл биш болов уу.

## ТАВАН ШИНЕЛЬ БҮРИЙН НЭГ НЬ “МОНГОЛЫНХ”

Дайны бүх жилүүдийн турш Монголоос бас нэг стратегийн бараа нийлүүлж байсан нь ноос. Ноос нь юуны өмнө цэргийн шинель болдог байсан бөгөөд тэр үед манай улс 64 мянган тонн ноос нийлүүлсэн юм. 1942-1945 онд Зөвлөлтийн цэргийн таван шинель бүрийн нэг нь Монголын ноосоор хийсэн байлаа. Монгол Улс цэргийн үстэй дээл, үстэй малгай, бээлий, эсгий гутлыг дайны анхны жилийн намар нийлүүлж эхэлсэн. 1941 оны 11 дүгээр сарын эхээр Москвагийн дэргэдэх сөрөг тулалдаанд бэлтгэхэд Зөвлөлтийн явган цэргийн хэд хэдэн дивизийн цэргүүдийг манай оёдолчдын өбсөн өвлийн хувцсаар бүрэн хангасан байсан. Дайны жилүүдэд ЗХУ-д олдож байсан гянт болдын цорын ганц үйлдвэрлэлийн ач холбогдол



Фронтын хэрэгцээнд ноос, нэхий бэлтгэж байгаа нь

бүхий нөөц нь Монгол Улсад байсан юм. Гянт болд бол дэлхий дээрх хамгийн их галд тэсвэртэй, хайлц муутай металл бөгөөд түүнгүйгээр Германы “барс”, “ирвэс” танкийн хуягийг нэвт цохих чадвартай сум үйлдвэрлэх боломжгүй байлаа гэж бичсэн байдаг.

Үүнээс гадна Бүгд Найрамдах Монгол Ард Улс Бүх нийтээр цэргийн алба хаах тухай хууль гаргаж улсынхаа төсвийн талаас илүү хувийг цэргийн хүчийг зузаатгахад зарцуулан 1941-1945 онд цэргийнхээ тоог 4 дахин нэмэгдүүлсэн ба ЗХУ-ын дорнод тал дахь Японыг эсэргүүцэх армийн нэмэгдэл хүч болсноор Зөвлөлт-Германы фронтод хүчээ төвлөрүүлэх боломж олгосон стратегийн үүрэг гүйцэтгэсэн юм.

Ингэж дөрвөн жил гаруй үргэлжилсэн Зөвлөлтийн Аугаа Эх орны болон дэлхийн хоёрдугаар дайны үед БНМАУ, ЗХУ-тай ямагт хамт байж, нийтийн ялалтын төлөө чадах бүхнээ зориулсан түүхтэй. Монголын ард түмний энэхүү тусламж нь дэлхийн том дайны гол хүндийг үүрсэн Зөвлөлт Холбоот Улс, Улаан армийн нийт хэрэгцээ, хангалттай харьцуулахад их биш харагдах ч тухайн үед 800,000 хүн амтай Бүгд Найрамдах Монгол Ард Улс, түүний ард түмний бүх боломжоо дайчилж, чадах бүхнээ зориулсан чин сэтгэлийн илэрхийлэл байсан. Ингэж чадсанаараа Зөвлөлтийн ард түмэнд сэтгэл санааны дэмжлэг болж, Улаан цэргийн ялалтад зохих үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой. Нөгөө талаар энэхүү тусламж, дэмжлэг нь хүн төрөлхтний дайсан болж байсан фашизмыг ялахад Монголын ард түмнээс оруулсан хувь нэмэр, Зөвлөлтийн ард түмэнтэй хамт ялалт байгуулсны нэгэн илэрхийлэл болж байгаа юм.

Бэлтгэл хурандаа Г.ЛҮНДЭН

АУГАА ЭХ ОРНЫ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙД

## ДЭЛХИЙН ХОЁРДУГААР ДАЙН ЭХЛЭХЭД МОСКВА ХОТОД ЦЭРГИЙН АКАДЕМИД СУРАЛЦАЖ БАЙСАН ААВЫНХАА ДУРСАМЖААС ...

Миний аав хурандаа Ж.Рэнцэн нь 1914 онд одоогийн Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт төрсөн. 1932 онд бүрэн дунд сургууль төгссөн. 1937-1955 онд хуучнаар Зөвлөлт Холбоот Улсад улс төрийн ажилтны курс, Цэрэг-улс төрийн академи, Монгол Улсын их сургуульд тус тус суралцаж төгссөн. Тэрээр 1932 оноос сумын бичиг үсгийн багш, "Битүү эрэг" багийн дарга, Цагааннуурын дамжлага базад дэлгүүрийн эрхлэгчээр ажиллаж байсан. 1935 онд цэргийн албанд татагдан Ховдын дөрөвдүгээр морьт хорооны хөгжим ангид цэрэг-номын багш, 1939-1943 онд Цэргийн ерөнхий сургуульд багш, Дорноговь аймаг дахь 10 дугаар морьт дивиз, Дорнод аймаг дахь 5 дугаар морьт дивизийн комиссар, 1943-1951 онд Хязгаарын цэргийн Улс төрийн хэлтсийн дарга, отрядын дарга, төв сургуулийн захирал, 1955-1962 онд Ховд аймгийн намын хорооны нарийн бичгийн дарга, Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын намын хорооны нарийн бичгийн дарга, 1962-1975 онд Улаанбаатар хотын комендантын улс төрийн орлогч, Батлан хамгаалах, хөдөлмөр нийгэмлэгийн төв зөвлөлд хэлтсийн дарга, Иргэний хамгаалалтын газарт хэлтсийн даргаар тус тус ажиллаж байсан юм.

Аав маань 1939 оны Халхын голын байлдааны үед 10 дугаар морьт дивизийн комиссараар ажиллаж байхдаа Дорноговь аймгийн нутагт Өлгийн хийдээс Сулинхээрийн чиглэлд байрлах улсын хилийг сахин хамгаалах үйл хэрэгт зүтгэсэн бөгөөд 1943 онд баруун хилийн зэвсэгт тулгаралтад оролцон Шинжаан, Шар сүмийн чиглэлд байлдааны үүрэг гүйцэтгэжээ. Мөн 1945 оны Чөлөөлөх дайны үед Дорнодын чиглэлээр Барга хошуудын төв Алтан эмээлийг чөлөөлөхөд оролцож, Манжуур, Хайлаар хотын чиглэлд байлдааны үүрэг гүйцэтгэн идэр залуу насаа эх орноо батлан хамгаалах их үйлст зориулсан тухайгаа бидэнд байнга дурсдаг байлаа.

Түүний хөдөлмөр, зүтгэлийг



төр, засгаас өндөрөөр үнэлж Сүхбаатарын одон, Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Байлдааны гавьяаны одон, "Алтан гадас" одон болон ЗХУ-ын Улаан таван хошуу одонг хоёр удаа хүртээсэн бөгөөд түүнд медалиудаар шагнасан юм. Түүнд БНМАУ-ын Цэргийн явдлын яамны сайд, Бүх цэргийн жанжны тушаалаар дивизийн комиссар цол хүртээсэн ба 1943 оны 11 дүгээр сард хурандаа цол мөн 1983 онд Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн цолыг олгосон.

Миний аав улс, армид 43 жил тасралтгүй ажиллаж байгаад гавьяаныхаа амралтыг эдэлж, хүү, охин, хүргэн, бэр, ач, зээ нарынхаа хамт амар амгалан амьдарч байгаад 2002 онд 85 насандаа хорвоогийн мөнх бусыг үзүүлэн бурхны орноо заларч бидэндээ сэтгэлийн зул болж мөнхөрсөн юм.

Ингээд би бээр аавынхаа бичиж үлдээсэн дурсамжийн хэсгээс эрхэм уншигч танд толилуулахыг хүссэн юм. Аавын дурсамжид өгүүлснээр "Би Дорнод аймаг дахь Баянтүмний 5 дугаар дивизийн комиссараар ажиллаж байхад 1941 оны зун ЗХУ-д В.И.Лениний нэрэмжит Цэрэг-улс төрийн академид явж суралцах албан тушаалтнуудын тоонд багтаан Улс төрийн газраас дуудсан учир Улаанбаатар хотноо ирвэ. Би өмнө нь Улс төрийн ажилтны курст суралцсан бөгөөд энэ

удаа дахин ЗХУ-ын Москва хотод суралцах болов. Монголын Ардын Армийн улс төрийн ажилтан болох бидний хэдэн нөхөд 1941 оны 6 дугаар сарын 29-ний өдөр улсын хилээр гарч, Москва хот дахь Цэрэг-улс төрийн академид суралцахаар сургуульдаа хүрэлцэн очсон юм. Биднийг Хуурай замын цэргийн факультетэд бүртгэн авч Зөвлөлтийн армийн цэргийн дүрэмт хувцсаар хувцасласан бөгөөд бидэнд орос нэр өглөө. Энэ үед С. Равдан (хожим Улсын Иргэний хамгаалалтын газрын даргаар ажиллаж байсан, хурандаа генерал)-г Семен Рабданов, Л.Тойв (ГЯЯ-ны сайдаар ажиллаж байсан, хурандаа)-ыг Владимиров, Л.Цэрэндорж (Хилийн ба Дотоодын цэргийг удирдах ерөнхий газрын Улс төрийн хэлтсийн орлогчоор ажиллаж байсан, хурандаа) Очиров хэмээн нэрлэсэн ба намайг Эрнстов Сергей Эрнстович хэмээх өмнө нь 1937 онд өгсөн нэрээрээ нэрлэх болов. Энэ үед дайны үеийн шаардлагаас академид суралцах программ, хугацаа шахуу байж, түүгээр бэлтгэгдсэн улс төрийн ажилтныг фронтод явуулж байв.

Бид, тэдний хамт тасаг, салааны зохион байгуулалтад орж зөвсэглэснээр байлдааны үүрэг гүйцэтгэж эхлэв. Би тасгийн хөнгөн пулемётын наводчик болов. Цэргийн дэг журам, сахилга улам чангарч тасаг, салааны захирагчийн команд болон жагсаалгүйгээр гадагш үл гарна. Тус академийн зуслан Москва хотоос баруун тийш 60 гаруй километр зайтай Можайскийн дардан замын ойролцоох Кубинка тосгонд байсан юм. Бид дайсны бөмбөгдөлт, их бууны галын дор академийн зуслангийн байрны хамгаалалтыг хийж окол, шуудуу ухах, нуувч бэхлэлт барин, жижүүр манаа, харуулын албыг гүйцэтгэдэг байв. Дайны байдал хүндэрсэн Смоленскийн тулалдааны дараа манай академийг Москва хот руу шилжүүлэн Москваг хамгаалах цэргийн бүрэлдэхүүнд оруулсан болно. Шаардлагатай үед Москва дахь засмал замыг хамгаалах үүрэг тус академид ноогдов. Бид засмал замын дагуух барилга байгууламж,

гудамж талбай, байшингийн дээвэр, хонгил зэрэгт эргүүл, харуул манааны үүрэг гүйцэтгэж байлаа. Дайсан Москвад ойрхон ирсэн тул командлалын тушаалаар өөр байрлалд нүүлгэн шилжүүлэх болсныг бидэнд мэдэгдлээ.

Москвагаас гарах үед рот, курсийн дарга нар байлдааны бүрэн бэлэн байдалтай явахыг тушааж, явах замд энгийн иргэд, дайнын хүмүүстэй ярьж харилцахыг хориглон дайсны хорлон сүйтгэх бүлэг болон дайсны эргүүл, хамгаалалттай таарвал хэрхэн няцаахыг тайлбарлаж явав. Бид 1941 оны 11 дүгээр сард Башкирийн Автономит Бүгд Найрамдах Улсын Белебей хотод ирж байрлав. Тэнд бидний хичээл өдөртөө 12-14 цаг үргэлжлэх ба өдөр нь буудлага, тактикийн хичээл, орой нь онолын хичээлүүд орж байлаа. Тухайн өдрүүдэд бид

Тэр тухайгаа одоо эргэцүүлэн бодоход бахархал төрдөг юм" хэмээн хуучилсан юм.

Мөн аав маань "Академийн бүрэн курс төгсгөх шалгалтыг марксист, ленинист онолын үндэс, цэргийн урлаг, түүх, газрын зураг, байлдааны болон буудлагын бэлтгэл, улаан армийн нам, улс төрийн ажил зэрэг арав гаруй сэдвээр өгч билээ. Академийн шалгалтын комисс бидэнд цэргийн улс төрийн мэргэжлийн ажилтан гэдсэн диплом олгов. Академийн эрхэм шинжилгээ, сургалтын ажил эрхэлсэн орлогч дарга А.Шербаков бидэнд та нар зориг чадалтай, сайхан залуус юм. Та нар байлдааны талбар дээр болж байгаа өөрчлөлт, шинэ арга, тактик, зэвсэг, техникийн хүч чадлыг судалж эзэмшсэн тул байлдааны үед болон сургалт бэлтгэлийн үеийн буудлагын хороо,



Зураг дээр, зүүн гар талаас: Хурандаа генерал С.Равдан, хурандаа О.Цэрэндорж, хурандаа Ж.Рэнцэн, хурандаа Х.Дондов

байлдааны нөхцөлд хүндрүүлсэн сургуулийг хийж, түгшүүрийн дохиогоор 60, 70 километрийн маршийг шөнийн цагаар үйлдэхдээ пулемёт үрч тэсгим хүйтэн, гүн зузаан цасанд цанаар явж, заримдаа хөл дээрээ тэнцэн зогсож чадахгүй туйлдан ядарснаар байрандаа мөлхөж орох явдал ч тохиолдож байв. Дайны үед картын систем хатуу тогтож, зөвхөн хоолны газарт нормын хэрчим талх, ногооны таваг шөлөөс илүү юм үл олдоно. Бид тийнхүү дайны үед Зөвлөлтийн анд нөхөдтэй мөр зэрэгцэн зовлон, жаргалаа хуваалцаж явсан билээ.

дивизийг удирдаж чадах бэлтгэлтэй гэж үзэж байна. Фашист германы холбоотон японы милитаристууд Дорно зүгээс довтолж болзошгүй. Та бүхэн даруйхан буцах шаардлагатай байна гэж ярьж билээ. Ийнхүү бид академид нэг жилийн хугацаанд төгсөж ирсэн ба би бээр 1942 оны наймдугаар сарын эхээр 5 дугаар морьт дивизийн комиссараар дахин томилогдсон юм" гэсэн аавынхаа дурсамжийг Аугаа Эх орны дайны ялалтын 75 жилийн ойн баярын өдөр дэлгэж байгаадаа туйлын баяртай байна.

Бэлтгэл хошууч Р.ОЮУНЧИМЭГ

## АУГАА ЭХ ОРНЫ ДАЙНЫ ЯЛАЛТЫН БЭЛГЭ ТЭМДГҮҮД

"Агуу Эх орны дайн" хэмээн "Правда" сонини 1941 оны 6 дугаар сарын 23-ны дугаарт бичсэн байдаг. Үүнээс өмнө Зөвлөлтийн сонин, хэвлэлээр "Ард түмний ариун дайн", "Эх орон, ард түмний ариун дайн", "Ялалт авчрах Эх орны дайн" гэх мэтчилэн янз бүрээр бичиж байжээ. Харин 1942 онд гарсан дайны шинэ одон дээр "Эх орны дайн" гэж үгийг бичсэн нь бидний өдийг болтол хэлж заншсан "Агуу Эх орны дайн" хэмээх нэршлийг албан ёсны болгон баталгаажуулсан байна.

### ГЭГЭЭН ГЕОРГИЕВЫН ТУУЗ

Дэлхийн хоёрдугаар дайны ялалтын бэлгэ тэмдгүүд дундаас хамгийн сүүлд хэрэглэгдэж эхэлсэн зүйл бол улбар шар, хар өнгийн Гэгээн Георгиевын тууз юм.

Энэхүү тууз нь 1812 онд Наполеоны армийг бут цохиж, Оросын эзэнт гүрнийг чөлөөлсөн жанжин М.И.Кутузовт шагнасан Гэгээн Георгиевын одонгийн тууз аж. Хожмоо Эх орны дайны жилүүдэд бүтээгдсэн "Гвардын одон"-д энэхүү туузыг хэрэглэх болсон тул "Гвардын тууз" ч гэж нэрлэх нь бий. Тус одонг 1941-1945 оны хооронд дайны фронтод тулалдаж байсан, ялалтад хувь нэмрээ оруулж, гавьяа байгуулсан бүх хүнд олгожээ.

Гэхдээ Эх орны дайны ялалтын 60 жилийн ойг хүртэл уг туузыг төдийлөн ач холбогдол өгч ашигладаггүй байв. Харин 2005 онд Москвагийн "Оюутны нийгэмлэг" Төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн "РИА Новости" агентлагаас санаачлан "Георгиевын тууз" аяныг өрнүүлсэн нь аугаа ялалтын бэлгэ тэмдэг болсон түүхтэй юм.

### ЭХ ОРОН ДУУДАЖ БАЙНА

Баруун гартаа цэргийн тангараг барьж, зүүн гараараа уриалан дуудаж байгаа эх хүний сэтгэл зовнисон ч эрс шийдэмгий харц бүхий плакат Эх орны дайны жилүүдэд хийгдсэн маш хүчтэй ухуулах хуудас болж чадсан юм. Энэхүү ухуулах хуудас нь Зөвлөлтийн зураач Ираклий Моисеевич Тоидзийн бүтээл бөгөөд зураг дээр дүрслэгдсэн эмэгтэй нь түүний эхнэр аж. Ухуулах хуудасны хэрхэн бүтсэн талаар түүний хүү Ираклия Моисеевич "Дайн болсон талаарх мэдээг эж сонсоод санаа зовсон тийм нэг царай гаргасан юм. Харин аав шууд л ээжийг "Битгий хөдөл, яг ингээд зогсож бай" гэж хэлээд



сонсоод санаа зовсон тийм нэг царай гаргасан юм. Харин аав шууд л ээжийг "Битгий хөдөл, яг ингээд зогсож бай" гэж хэлээд

зурж эхэлсэн. Маргааш өглөө нь зурж дууссан бол тав хоногийн дараа сонинд хэвлэгдэж гарсан" хэмээн дурссан байдаг. Мөн энэхүү ухуулах хуудас нь орчин үед зар сурталчилгааны салбарт маш олон агуулгатайгаар ашиглагдаж байгаа билээ.

### КОМБАТ

Цэргүүдээ уриалан дуудаж давшилтад орж байгаа даргын зураг нь Эх орны дайны үеийн хамгийн алдартай гэрэл зургийн нэг юм. Уг гэрэл зургийг Украины Луганск мужийн



Славяносербскийн район дахь Луганы болон Лозовая голын дунд явагдсан 1941 оны 7 дугаар сарын 12-ны өдрийн тулалдааны үеэр Макс Альперт гэрэл зургийн хальснаа буулгаж чаджээ. Зургаа "Комбат" буюу командир батальон гэж нэрлэсэн нь сонин түүхтэй. Тэр бээр уг зургийг дарсан ч төд удалгүй сумны хэлтэрхий аппаратыг нь гэмтээчээ. Тэгээд авсан зураг нь гэрэл цохин нэгэнт гарахаасаа өнгөрлөө гэж бодоод тухайн зургийнхаа баатрын нэр, цол, албан тушаалыг нь асуугаагүй аж. Гэтэл азаар хальс нь гэмтээгүй, цаашлаад маш чанартай зураг гарч ирсэн байна. Хожим зураг нь алдаршиж, Эх орны дайны шилдэг батальоны захирагчийн бэлгэ тэмдэг болсон зургийн баатрын нэр нь тодорхой болжээ. Тэр бээр 1906 онд төрсөн Алексей Гордеевич Еременко юм. Зураг даруулсан өдрийн өглөө ротын захирагч, ахлах дэслэгч Петренко шархадсан тул улс төрийн орлогч Еременко түүнийг орлон ротоо удирдан тулалдаанд орсон нь гэрэл зурагт мөнхрөн үлджээ. Зураг авснаас хэдхэн секундний дараа амиа алдсан ч энэ зургаараа дайныг дуустал олон сая цэргүүдэд эх орноо хамгаалах урам зориг өгч, дайны сэдэвт түүхийн кино бүрд "Миний арас! Эх орныхоо төлөө! Урагшаа!" хэмээх үг нь заавал хэлэгддэг болсон билээ.

### ГУРВАН СУРАГЧИЙН НЭГ ӨНЦӨГ

Аугаа Эх орны дайны ялалтын баярын тухай ном, сэтгүүл болгонд зайлшгүй байдаг зураг нь Рейхстагийн оройд ЗХУ-ын тугийг мандуулж байгаа гэрэл зураг юм.

1945 оны 4 дүгээр сард Берлинд дөхөж очсон Улаан армийн ангиудад Берлинийг эзэлж, ЗХУ-ын далбааг Рейхстагийн оройд мандуулах үүрэг өгсөн байна. Тухайлбал, 1945 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр 3 дугаар цохилтын армид есөн ширхэг тус өгсөн бөгөөд дайчин болгон Рейхстагийн оройд ялалтын улаан тугийг мандуулахыг хүсэж байлаа. Рейхстагийн



оройд хэн хамгийн түрүүнд тугаа мандуулсан талаар одоо ч түүхчид маргадаг. Зарим эх сурвалжид, 4 дүгээр сарын 30-ны өдөр Рейхстагийн оройд улаан туг мандуулсан боловч нэгэн герман цэрэг буулгасан тул дараа нь дахин мандуулсан гэдэг ч энэ баримтыг нотлох зүйл одоо болтол олдоогүй юм. Мөн Берлинийг чөлөөлөх үед "ТАСС"-ын Евгений Халдей, "Правда" сонини Виктор Темин, Зөвлөлтийн мэдээллийн хорооны Владимир Гребнев нарын гурван гэрэл зурагчин байсан нь түүхчдийн маргааны бүр ч ээдрээтэй болгодог аж.

1945 оны 5 дугаар сарын 1, 2-ны өдөр кино найруулагч Роман Кармен онгоцоор Рейхстагийн оройд намирах улаан тугийн дүрс бичлэгийг агаараас авах үед Виктор Темин зураг авсан бол Евгений Халдей, Владимир Гребнев хоёр 5 дугаар сарын 2-ны өдөр Рейхстагийн оройд дээр гарч бараг ижил шахам гэрэл зураг авчээ. Тэр хоёрын зургийн ялгаа нь салхинд хийссэн тугны чиг л өөр байсан аж. Одоог болтол энэхүү гэрэл зургийг яг хэн нь авсан талаар баттай баримт байдаггүй аж.

Мөн аливаа туг, далбаа нь нэг стандарттай байдаг бол Рейхстагийн дээр мандсан туг нь өргөнөөрөө 3 сантиметр, уртаасаа 73 сантиметрээр бага байсан аж. Учир нь цэргүүд дурсгал болгон цуулж авсан байх магадлалтай бөгөөд хэн ч түүнийг ялалтын туг болно гэж бодоогүй нь ойлгомжтой юм. Дайн дуусаж Рейхстагийн ордныг засварлах үед дээрээс 160 гаруй туг буулгасан байна.

### ЯЛАЛТЫН ПАРАД

Эх орны дайны анхны ялалтын парад нь 1945 оны 5 дугаар сарын 4-ний өдөр Берлин хотын Бранденбургийн хаалганы дэргэд болж байжээ. Харин Улаан талбай дээр 1945 оны 6 дугаар сарын 24-ний өдөр явагдаж ЗХУ-ын маршал К.К.Рокоссовский командалж, маршал Г.К.Жуковт илтгэл өгсөн байна. Энэхүү парадд 9000 цэрэг оролцож, 20 минут үргэлжилжээ.

Яагаад И.Сталиныг өөрөө парадд илтгэл аваагүй талаар одоог болтол тодорхойгүй байдаг. Маршал Г.К.Жуковын дуртгал номонд "Парадын өмнө И.Сталин түүнийг дуудаж бэлтгэл хэр хангагдсан, Рокоссовский ямар морь унах талаар асууж, өөрөө парадыг хүлээж авахгүй байгаа шалтгаанаа настайгаа холбон тайлбарласан" хэмээн бичсэн байдаг.

Мөн анхны ялалтын параддас эхлэн 1949 оныг хүртэл 5 дугаар сарын 9-ний өдрийг ЗХУ-ын хэмжээнд баярын өдөр гэж үзэн, бүх нийтийн амралтын өдөр болгож байсан бол 1949-1965 оны хооронд уг өдөр бүх нийтээр амраахаа больсон байна.

АУГАА ЭХ ОРНЫ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙД

# Чээл, буу хоёроор байлдсан яруу найрагчид

**ЭХ ОРНОО ХАЙРЛАХУЙН УХААН ЯРУУ НАЙРГИЙН ХЭЛЭЭР**

Эх орноо хайрлах, эх оронч үзэл, ухамсар, итгэл, үнэмшлийг “Миний төрж өссөн нутаг, энэ хорвоод хүн болохдоо хөрсөн дээр нь эхийн хэвлийгээс унаж, агаарыг нь амьсгалж, усыг нь ууж хүний зэрэгт хүрсэн өлгий минь” гэх мэтээр жирийн сэтгэл хөөрөл, догдлол, дасан зохицох ээнэгшлийн хүрээгээр хязгаарлан ойлгож үл болох аж. Философичдын хялбаршуулан нэрлэдгээр хоёрдох байгаль болдог төрөлх уламжлалт соёл-ард түмний зан заншил, ардын билиг сургаал, үлгэр домог, шашин, урлаг, уран зохиол, эрх зүйн тогтолцоо ... гээд бүхэлдээ бидний амьдрах арга ухаан, эх орныг минь бүхэл болгож цогцлоодог.

**НЭГ. ЭХ ОРНЫ ТУХАЙ БАДГУУД**

**МИХАЙЛ МАТУСОВСКИЙН** “Эх орон чухам юунаас

эхэлдэг вэ?” шүлэг биднийг бодол, эргэцүүллийн замд хөтөлнө.

**Эх орон чухам юунаас эхэлдэг вэ?**

**Чиний цагаан толгойн номын зургаас уу?**

**Эсвэл хамар хашаанд амьдарч буй**

**Чин үнэнч, итгэлт сайн нөхрөөс үү?**

**Эсвэл тэр эх орон гэдэг чинь**

**Ээжийн минь дуулсан дуунаас уу?**

**Хэцүү бэрх тулалдааны үед**

**Хэнд ч дийлдээгүй тэр нууцаас уу?** гээд л “Бүрэг залуу наснаас тээж явсан, Галтай зүрхний чинь тангаргаас уу?” хэмээн үргэлжлэх найрагчийн энэ шүлгийн мөрүүдийг монгол хүн бол юу юу гэж шүлэглэн нэмэх бол ...

**СЕРГЕЙ СМИРНОВ:**

**Эх орон**

**Элэг зүрхний гүнд**

**Эрхэм эрдэнэ Танаас өөр даанч үгүй.**

**Энд бид өөрсдийн хүчээ сорьсон**

**Эзэн иргэнийхээ төрхөө олсон**

**Бүхий л ажлыг чин сэтгэлээсээ хийж,**

**Бэлэг болгон барьж, гайхамшигт үйлс бүтээж өгсөн**

**Эх орон таны өмнө тайлангаа тавих**

**Эр сэтгэлийн тэнхээ хэзээ ч харихгүй** (Х.Хангайсайханы орчуулга) гэж эх орон, иргэн хоёр хүйн холбоотойг илхэн хэлжээ.

**ЕВГЕНИЙ ЕВТУШИНКО** 1961 онд “Оросууд дайн хүсдэг гэж үү?” шүлгээ бичиж хүн төрөлхтөнд жирийн орос найрагчийн үнэн зүрхний үгээ хүргэжээ. Амьдарч ахуй үеийнх нь хүний хорвоогийн, нийгмийн орчин цагийн хувирал, мэдрэмж, ухаарал яруу найрагчийн зүрхэн дундуур туучиж өнгөрдөг.

**Орос нутгийн хусан дор нойрсох**

**Тэр дайчин эрсээс асуугаарай**

**Онцолж хөвгүүд нь хэлэх байх**

**Оросууд дайн хүсдэг гэж үү?**

**Эх орныхоо төлөө, зөвхөн**

**Эр цэргүүд дайнд эрсдээгүй ээ**

**Замбуулинд та тайван унтаа гэж**

**Залуус, тэр дайнд үрэгдсэн юм аа ...**

**Үзтэл бид байлдаж сурсан ч гэлээ**

**Үнэндээ бид дайн хүсээгүй ээ**

**Эр цэрэг тулалдааны талбарт үрэгдэж**

**Энэ гунигт газартаа шингэх ёсгүй ээ**

**Бэлэвсэрч хоцорсон эхчүүлээс асуу**

**Бидний хайртай эхнэрүүдээс асуу**

**Өнөө тэгвэл та ойлгох байх шүү**

**Оросууд дайн хүсдэг гэж үү?** (Х.Хангайсайханы орчуулга)

**ВЛАДИМИР ХАРИТОНОВ:**

**Ялалтын өдөр**

**Яг л унтарч буй түүдгийн бүдэг цуцал шиг**

**Ялалтын өдөр биднээс ямар хол байсан гэх вэ ...**

**Түймэрт хуйлагдсан зам харгуйг туулан байж**

**Тэр өдрийг бид чадахын хэрээр наашлуулсан юм**

**Ялалтын энэ өдөр**

**Дарь хүхрээр ханхалсан**

**Ялгуулсан энэ өдөр**

**Үс бууралтуулж ирсэн**

**Ягдсан сэтгэлийн**

**Баярын нулимстай угтсан**

**Ялалтын өдөр! ялалтын өдөр!**

**Мартыновын уурын зуухны дэргэд өдөр, шөнөгүй**

**Манай эх орон нүд цавчилгүй ажилласан**

**Тэнцвэргүй тулалдааныг өдөр шөнөгүй хийж**

**Тэр өдрийг бид чадахын хэрээр наашлуулсан юм**

**Ялалтын өдөр! Ялалтын өдөр!**

**Сайн байна уу, ээж ээ, бид бүгдээр ирсэнгүй ээ ...**

**Шүүдрийн усыг хөл нүцгэн туучин гүймээр ээ ...**

**Тэнүүн орчлонгийн тал, Европын хагасыг туулан**

**Тэр өдрийг бид чадахын хэрээр наашлуулсан юм**

**Ялалтын өдөр! Ялалтын өдөр!**

Дэлхийн хоёрдугаар дайны аймшиг, түгшүүрээр хүрхэрсэн он жилүүдэд 55 сая хүнийхээ халуун амийг гранат, бөмбөгний дэлбэрэлт, шөргөн галд шатаасан хүмүүний ертөнц жил бүрийн 5 дугаар сарын 9-ний өдөр энэ дууг сонсож, туулж өнгөрөөсөн гашуун хувь заяагаа дэнслэн бодож, дурсан санаж, толгой мэхийдэг.

Монгол хэлээр “Василий Тёркин” алдарт найраглал нь орчуулагдсан **АЛЕКСАНДР ТВАРДОВСКИЙ** 1945 оны 8 дугаар сарын 3-ны өдөр:

**Бүх дэлхийн хүн ард аа**

**Билэгт сайн цагийг баяртай угтацгаа**

**Газар тэнгэрийг нэлд нь донсолгосон**

**Гамшигт хар дайны жилүүд дууслаа**

**Улайссан бууны төмөр арайхан хөрөөгүй ч**

**Урссан цус минь газарт бүрэн шингээгүй ч**

**Энх цаг ирлээ. Дайны босгыг давсан,**

**Эрхт олон минь алжаалаа тайлцгаа ...** хэмээн бичиж байжээ. Хортон дайсны галын дор 1418 хоног ажиллаж, амьдарсан ард түмэнд дайн төгсөнө гэдэг хүний нэгэн насанд тохиолдож болох юутай зүйрлэх, азтай ч гэмээр ямар үйл явдал болохыг ёстой л үгээр илэрхийлж хэлэх аргагүй аж.

**ХОЁР. ЦЭРЭГ ЭРИЙН ЗҮРХНИЙ БИЧЭЭС**

1941 оны 7 дугаар сард Ленинградын хориглолтын үеэр **АННА АХМАТОВА:**

**Хайртаасаа өнөөдөр хагацаж буй хөөрхий бүсгүй**

**Хамаг зовлонгоо сэтгэлийн тэнхээ болгож хувиргаг**

**Үр хүүхдүүдээ ч, үрэгдэгсдийн даруу булшинд ч**

**Үүрд тангараглая, хэн ч биднийг өвдөг сөхрүүлэхгүй!** гэж бичжээ. Яруу найрагчийн энэ дөрвөн мөр орос хүний сэтгэлийн өчил, чин зүрхний тангараг байлаа. Гитлер 1941 оны 6 дугаар сарын 22-ны үүрээр Зөвлөлт Холбоот Улсын хил рүү цөмөрч гэнэтийн цохилт өгснөөр цахилгаан дайнаа эхлэхдээ 1941 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр Ленинград хотын “Астора” зочид буудалд ялалтын баярын цайллагыг хийнэ гэж төлөвлөөд байжээ. Харин түүхэн үйл явц огт өөрөөр эргэж, Ленинград хот 900 хоног бүслэлтэд амьдарч, тулалдсаар фашист германы цэргийн галзуурсан дайралт, давшилтуудыг няцаасаар, тэсч тогтсоор ялж гарсныг түүх мартахгүй. Энэ бүслэлтийн нэгэн эгшиг алдарт найрагч **НИКОЛАЙ ТИХОНОВ:**

**“Хар дарсан аймшигт зүүд мэт Ленинградын сүрлэг шөнүүдэд Харанхуйд хучигдсан аварга барилга Бүслэлтийн дунд нам гүм байлаа Тэр чимээгүйг тулалдаан цочоож Байраа эзлэхийг түгшүүр дуудан Тэнд Нева дээгүүр бөмбөг исгэрч Бадарсан гал гүүрийг түймэрдэн Шөнийн агаарын довтолол дунд Холын бууны дуу нижигнэж байхад”**

(М.Цэдэндоржийн орчуулга) гэж дүрсэлжээ.

**ВИКТОР КОЧЕТКОВ:**

**Үхлийн тулалдаан хаа сайгүй болж**

**Газар дэлхий түймрийн галд хуйхлагдаж**

**Уудам орчлонгийн орон зай хумигдаж байсан юм**

**Дэндүү зориг шулуун, итгэл дүүрэн тулалдаж**

**Дэлхийн орон зайг орос цэрэг хамгаалж гарсан юм.** (Х.Хангайсайханы орчуулга)

Яруу найрагч **АЛЕКСАНДР ТВАРДОВСКИЙ** “Танкчны яриа” шүлэгтээ:

**“Аюулт дайны гамшигт өртсөн хотод Аж төрж байсан хүүхдүүдийн нэг л дээ Биднийг зогсонгуут хүүхдүүд хүрээлээд ирнэ Бидэнд ус зөөж чадахаараа тусална Дайчдад алчуур, саван авчирч өгнө Дутуу боловсорсон жимс ч барьж гүйлдэнэ Хотын гол гудамжны төлөө тулалдаан болж Хортон дайсны гал улам ширүүсэж байлаа Төв талбай руу давшиж орлоо ч Түүнээс цааш авих аргагүй байлаа Дайсан хаанаас гал нээж буйг Даруй олж илрүүлэх төвөгтэй байлаа Нэг харахад бяцхан жаал хажууд ирчихсэн Нөхөр дарга аа, нөхөр дарга аа Тэдний их буу хаа байгааг би мэднэ Түрүүхэн цэцэрлэг рүү очиж тандаад ирсэн Би та нартай хамт явъя**

**Байгаа газрыг нь заагаад өгье гэдэг байгаа”** (Х.Хангайсайханы орчуулга) хэмээн танкчин дурсан ярьснаар шүлгээ зохиожээ. Эх орны дайны үед ёстой л найман настай балчраасаа наян настай буурлаа хүртэл эх орноо эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг эрслэн боссон юм. 25 сая хүнийхээ амь насаар дэнчин тавьж, мөн л өдий хэмжээний айл гэрт өнчрөл, ганцаардал авчирсан гамшигт дайны ялалтыг ард нийтийнхээ амь өрссөн тэмцлээр авчирсан ард түмний яруу найрагч л энэ дайныг “Бүх ардын ариун дайн байсан юм” гэж оноч үгээр нэрлэж чадах байлаа. Агуу Эх орны дайны хүнд хэцүүг үүрч гарсан Зөвлөлтийн арми, ард түмний дундаас 11 000 хүн ЗХУ-ын баатар эрхэм дээд цол хүртсэн баримт бас байдаг.

**МИХАЙЛ ЛЬВОВ:**

**Эр хүн гэж, эр болж төрөхийн нэр биш Төмөр байх гэдэг, хүдэр төдий зүйл биш Чи хүдэр шиг хайлж, бутарч чадах ёстой Чи хэрэгтэй цагт үхэж чадах учиртай Хар шуурга цээжийг чинь нэвт үлээг Харин цэрэг чи юунаас ч бүү шантар! Хонгор бүсгүйн үнсэлт, дайсны сумыг Хоёуланг нь хүлээж авах зоригтой бай Үхэлд бэлэн байх бас л хүчит зэвсэг Үнэндээ тийм хором чамд гарцаагүй ирнэ...**

(Хангайсаханы орчуулга)

Горькийн нэрэмжит утга зохиолын дээд сургууль төгссөн, 25-хан настай залуу яруу найрагч **КОНСТАНТИН СИМИНОВ** 1939 онд Халхын голын байлдааны үеэр манайд цэргийн сурвалжлагчийн томилолт өвөртлөөд ирж байжээ. “Алс Дорнод” мөчлөг шүлгийнхээ “Зэрэглээний тухай” хэсэгт

**Манай бригад Манхан дамжин явна Өндөрхаанаас эхлээд Өнөө хүртэл Халуун, элс хоёроос Хагацаагүй Хаагуур л бол элс Хуяг бүрхүүл нэвт орно Гар бууныхаа гэрийг нойтон алчуураар таглана Их бууныхаа голыг, хүүхэд адил хулдана Харах нүдээ Хааж боож болдоггүй болохоор Хоёр нүд төөнөрч улайгаад Зовхинд шингэсэн элсийг нь гаргах гэж Зулгаагаад хаямаар санагдана Зөндөөн удаан элс гоожиж Зовхиноос элсэн хэмжүүр шиг гарна”** гэж усгүй цөл, элсэн манхан дундуур мөлхөх байлдааны цуваанд яваа цэрэг эрсийн нэгэн өдрийг дүрсэлжээ. (М.Цэдэндоржийн орчуулга)

**ЮЛИЯ ДРУНИНАГИЙН** 1944 онд бичсэн энэ шүлэг нэг бодлын гунигтай нөгөө талаараа эр зоригийг дууль болсон үйл явдал өгүүлнэ.

**Уйлж, дуулж бас үнсэлцээд**

**Гардан байлдаанд бид шулуудсан юм.**

**Урагш давших тэр тулалдаанд орсон**

**Нөхөөстэй шинельтэй тэр бүсгүй**

**Гараа алдлан цасан дээр унасан юм.**

**Ээж, ээж ээ! Би зорилгодоо хүрлээ гэж**

**Энэ дуу тал, ижил мөрний эргээр хадаж**

**Нөхөөстэй шинельтэй нэг бүсгүй**

**Гараа алдлан цасан дээр унасан юм**

(Х.Хангайсайханы орчуулга)

**АНАТОЛИЙ СОФРОНОВ** найрагч “Огонёк” сэтгүүлийн ерөнхий эрхлэгчээр ажиллаж байхдаа монгол найрагч Б.Явуухуланг бурхны оронд халихад нь “Дорнын их яруу найрагч” гэсэн тодотголоор өргөмжилж байсан түүхтэй юм.

**Брянскийн ой сүртэй шуугина Буурал манан битүү бүрхэж Партизанууд яаж тулалдаанд орохыг Орчны нарс модод сонссон юм Хусан ойд шургасан замаар Харанхуй шугуй дундуур бэдрэн Хүнд сумтай винтов мөрөвчлөн Хүн бүхэн яарч явцгаасан юм Оросын гранат дээр нь бууж Ойн гүнээс дайсныг хөөн элдэж Ум хумгийг зугтах тэдний араас “Урагшаа” гэх захирагчийн дуу хадсан юм.**

(Х.Хангайсайханы орчуулга) Эх орны дайны үед партизаны бүхэл арми дайсны ард талд, төмөр зам, гүүр гарц, хот, сууринд тулалдаж, байлдаж байгаа армийнхаа байлдааны ажиллагаанд зүйрлэшгүй дөхөм үзүүлж, их ялалтад өөрсдийнхөө хувь нэмрийг оруулж байжээ.

**АНАТОЛИЙ ЖИГУЛИН:**

**Өгөрсөн гацуурууд Өнөө, булшин дээр сэрийлдэх нь Өнгөрсөн дайны үрэгдсэн цэргүүдийн Үүрч явсан буу шиг харагдана Хараацай элэн халин Хаа тэртээ ойн чанадаас ирэх нь Хөөрхий тэднийг минь сүнс эргэж Хүний хорвоогоор хэсүүчлэх шиг санагдана**

(Х.Хангайсайханы орчуулга)

**СЕМЁН ГУДЗЕНКО** “ Давшилтын өмнө” шүлэгтээ:

**Үхлийн өөдөөс дуу дуулж ордог**

**Үүний өмнө харин уйлж бас болдог**

**Үхлийн тулалдаанд хамгийн хэцүү нь**

**Давших тушаал хүлээх байдаг**

**Минийн дэлбэрэлтэд цас ярагдаж**

**Орчны газар хар үнсэр бүрхэгдэж**

**Миний хажуугаар үхэл дахин өнгөрч**

**Дайчин нэг нөхөр минь амьсгал хураалаа**

**Удахгүй миний үхэх ээлж ирнэ**

**Угаас намайг үхэл мөшгөж байгаа**

**Дохионы пуужин тэнгэрт хөөрөхийг**

**Цасан дунд цэргүүд хүлээж байгаа**

**Тэсрэх минийг өөртөө татах**

**Тийм нэг лайтай юм уу, би**

**Тэрүүхэнд дэлбэрэлт болж, дэслэгч өртлөө**

**Үхэл дахин миний хажуугаар өнгөрлөө**

**Бид цааш хүлээх аргагүй**

**Биднийг газар нуувчин доогуур**

**Дайсан этгээдийг жадаар сүлбэх**

**Даанч гашуун өшөө хорсол хөтөллөө”**

(Х.Хангайсайханы орчуулга) хэмээн амь өрссөн ширүүн тулалдааны өмнөх цэрэг хүний үхлээс үл айх шийдсэн эр зориг, тулаад ирсэн дайсантай нэгийгээ үзэн тулалдахаас зайлж үл болох хувь заяяныхаа тухай өгүүлжээ.

**ЯРАСЛОВ СМЕЛЯКОВ "Дуу" хэмээх шүлэгтээ:**

**Эх нь хүүдээ эрхэм жаргал хүссэн юм Эрэлхэг баатрын ёсоор хүү нь үхсэн хэвтэнэ Ээрэм талд, эх Зөвлөлт нутагтаа Эзэрхэг германы суманд хяргуулсан хэвтэнэ Эх нь охиндоо хурим төрийг хүссэн юм Энхрий охин нь амьсгал хураасан хэвтэнэ Энхрий охиныг нь шарман царайт ахлагч Эзгүй зооринд гурав хоног тамлажээ Цагаан гарыг мушгин шаналгажээ Цадиггүй муухай дарлан зовоожээ Гурван долоо хоног, орой бүр тамлаж Ганц ч үг тэр хүүхнээс сонссонгүй Хороож алахын өмнөхөн л харин Хоолойтойгоо мэдсэн юм шиг дуулсан гэнэ**

(М.Цэдэндоржийн орчуулга)

**ГУРАВ. ЦЭРЭГ ЭРСИЙН ЧИН ХАЙРЫН ЗАХИА КОНСТАНТИН СИМОНОВ** эхнэртээ бичсэн захиандаа “Хүлээ намайг, хүрээд ирнэ” шүлгээ бичиж илгээхдээ “Бусдад битгий дамжуулаарай, хэвлэлд ч өгөөгүй байгаа юм шүү” гэж анхааруулжээ. Гэтэл эхнэр нь найз бүсгүйдээ “Манай Алёша надад ийм шүлэгтэй захиа ирүүлсэн байна” хэмээн сэтгэл нь хөөрч догдлон уншиж өгчээ. Нөгөө найз бүсгүй бас өөр нэг найздаа энэ шүлгийг дамжуулснаар 1942 оны эхээр “Хүлээ намайг ...” шүлэг “Правда” сонинд нийтлэгдэхээс өмнө Зөвлөлт орон даяар аль хэдийн тарсан байжээ.

**Хүлээ намайг, хүрээд ирнэ**

**Хүлээхийн дээдээр хүлээ**

**Уйтгар нөмөрсөн**

**Усан борооноор ч хүлээ**

**Халуун, хүйтэнд ч хүлээ**

**Хар шамаргад ч хүлээ**

**Өчигдрөө мартсан**

**Өөр бусдыг дагалгүй хүлээ**

**Алсын холоос**

**Анир чимээгүй ч хүлээ**

**Амьтан бүхэн цөхөрсөн ч хүлээ**

**Хүлээ намайг, хүрээд ирнэ**

**Мартах болжээ гэж**

**Магадалж дагасан бүхнийг**

